



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ГҮЙЦЭТГЭГЧ: ЭС АЙ СИ ЭЙ ХХК

ТАЛАРХАЛ

“Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны баг “Авлигатай тэмцэх газар”-ын захиалгаар “Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээлэл цуглуулах, тайланг бэлтгэж, үр дүнг олон нийтэд мэдээлэх зөвлөх үйлчилгээ”-ний ажлыг 2023 оны 05 дугаар сараас 2023 оны 11 дүгээр сарын хооронд гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны ажлыг хэрэгжүүлэх боломжийг олгосон, судалгааны ажлын явцад үнэтэй зөвлөгөө, удирдамж, мэдээллээр хангасан “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олон, төрийн байгууллагуудын хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад талархал илэрхийлье.

Судалгаанд идэвхтэй хамрагдсан иргэд, төрийн байгууллагын албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид болон мэдээлэл цуглуулах ажлыг чадварлаг гүйцэтгэсэн талбарын судлаачдадаа талархал илэрхийлье.

Та бүхний хичээл зүтгэлээр энэхүү судалгааны ажлын үндсэн мэдээлэл цугларч, амжилттай тайлан бичих боломж бүрдсэн билээ.

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг хараат бус байдлаар “Эс Ай Си Эй” ХХК боловсруулсан.

Үр дүнг зөвхөн судалгаанд оролцогчдын үнэлгээний дүнд үндэслэсэн болно.

Судалгааны үр дүнг тухайн байгууллагын хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ), эсхүл авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтны үнэлгээ гэж ойлгож болохгүй.

СУДАЛГААНЫ БАГ

Судалгааны багийн ахлагч:

Г.Эрдэнэ (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Дэд захирал, докторант)

Тайлан боловсруулсан:

Э.Должин (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн захирал, докторант)

Т.Амаржаргал (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн менежер)

Х.Очирбат (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн менежер)

Б.Түмэндэлгэржав (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн менежер)

Мэдээлэл, цуглуулалтын баг:

Б.Төрцэцэг (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн захирал)

Ө.Халиун (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн менежер)

Б.Оюун-Эрдэнэ (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтсийн менежер)

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	1
СУДАЛГААНЫ БАГ	2
ХҮСНЭГТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	8
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	9
ХУРААНГУЙ	10
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	13
1.1. Зорилго, зорилт	13
1.2. Арга зүйн загвар, үнэлгээний утга	13
1.2.1. Үнэлгээний утга	13
1.2.2. Үнэлгээний загвар	13
1.2.3. Үнэлгээг тооцох арга	14
1.3. Судалгааны хамрах хүрээ	17
1.4. Түүврийн хэмжээ	17
1.5. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	17
1.6. Судалгааг хийхэд баримталсан зарчим	18
БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	19
2.1 Иргэн/хувь хүн, ААНБ-ын төлөөлөл	19
2.2. Албан хаагчдын төлөөлөл	19
2.3. Бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөлөл	20
БҮЛЭГ 3. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	21
3.1. Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн	21
3.1.1. ШБҮ-ний ерөнхий дүн	21
3.2.2. Дүүргүүдийн ЗДТГ-ын ШБҮ	26
3.2. Гадаад байдлын үнэлгээний ерөнхий үр дүн	27
3.2.1. Гадаад шударга байдлын ерөнхий үр дүн	27
3.2.2. Дүүргүүдийн ЗДТГ-ын гадаад шударга байдлын үнэлгээ	31
3.2.3. Авлигын эрсдэлийн индекс	31
3.2.4. Авлигын индекс	32
3.3 Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн	36
3.3.1. ДШБҮ-ний ерөнхий дүн	36
3.3.2. Соёлын индекс	40

3.3.3. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	41
3.3.4 Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ.....	42
3.4. БОУ-ний ерөнхий дүн.....	45
3.4.1. БОУ, дэд үзүүлэлтээр.....	49
3.4.2. Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ.....	51
БҮЛЭГ 4. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ.....	54
4.1. Монгол Улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал	54
4.2. Авлига хамгийн их тархсан институц	55
4.3. Монгол Улс дах авлигын шалтгаан	58
4.4. Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын талаар оролцогчдын санал.....	62
4.5. Ирэх 2 жилд Монгол Улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл	66
БҮЛЭГ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	68
ДҮГНЭЛТ	69
ЗӨВЛӨМЖ	72
ХАВСРАЛТУУД	75
ХАВСРАЛТ 1. ТҮҮВРИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ХУВААРИЛАЛТ	75
ХАВСРАЛТ 2. 2023 ОНЫ ҮНЭЛГЭЭ.....	77
ХАВСРАЛТ 3. ШБҮ, 2022, 2023 ОН.....	78
ХАВСРАЛТ 4. ГШБҮ – 2023, ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН.....	80
ХАВСРАЛТ 5. ДШБҮ – 2023, ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН	82
ХАВСРАЛТ 6. БОУ – 2023, ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН	84

ХҮСНЭГТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хэмжээст утгад шилжүүлэх загвар	15
Хүснэгт 2. Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах	16
Хүснэгт 3. Түүврийн хэмжээ	17
Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	19
Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	19
Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	20
Хүснэгт 7. ШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	23
Хүснэгт 8. ГШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	28
Хүснэгт 9. Яамдын ГШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор	28
Хүснэгт 10. Агентлагуудын ГШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор	29
Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор	30
Хүснэгт 12. Нийслэлийн ЗДТГ болон дүүргүүдийн ЗДТГ-уудын ГШБҮ, 2022, 2023, оноогоор	31
Хүснэгт 13. ДШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	37
Хүснэгт 14. Яамдын ДШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ	37
Хүснэгт 15. Агентлагуудын ДШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ	38
Хүснэгт 16. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ	39
Хүснэгт 17. Дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын индекс, дэд үзүүлэлтээр	44
Хүснэгт 18. Дүүргүүдийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	45
Хүснэгт 19. БОҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд	46
Хүснэгт 20. Яамдын БОҮ, 2022, 2023 оныг харьцуулсан байдлаар	47
Хүснэгт 21. Агентлагуудын БОҮ, 2022, 2023 оныг харьцуулсан байдлаар	47
Хүснэгт 22. ЗДТГ - уудын БОҮ , 2022, 2023 оныг харьцуулсан байдлаар	49
Хүснэгт 23. Авлига хамгийн их тархсан институц, оноор, нийт оролцогчдын хувьд	55
Хүснэгт 24. Монгол Улс дахь авлига хамгийн их тархсан институт, 2023	56
Хүснэгт 25. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор	57
Хүснэгт 26. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор	58
Хүснэгт 27. Тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд та юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?	62
График 1. Шударга байдлын үнэлгээ, оноогоор	21
График 2. ШБҮ, оролцогчдын төрлөөр, оноор	22
График 3. ШБҮ, байгууллагаар, оноор	22

График 4. Яамдын ШБҮ, 2023 он, оноогоор.....	24
График 5. Агентлагуудын ШБҮ, 2023 он, оноогоор.....	25
График 6. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ, 2023 он, оноогоор.....	26
График 7. Дүүргүүдийн ЗДТГ-ын 2023 оны ШБҮ.....	27
График 8. ГШБҮ, оноор, байгууллагын төрлөөр, оноогоор.....	27
График 9. Авлигын эрсдэлийн индекс, оноор, оноогоор.....	31
График 10. 2023 оны авлигын эрсдэлийн индекс, байгууллагын төрлөөр, оноогоор.....	32
График 11. Авлигын индекс, оноор, оноогоор.....	33
График 12. Авлигын индекс, байгууллагын төрлөөр, оноогоор.....	33
График 13. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг яг аль үед өгсөн, өгөх болсон шалтгаан.....	34
График 14. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг яг аль үед өгсөн бэ?, үйлчлүүлэгчдийн төрлөөр.....	34
График 15. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив зэргийг өгөх болсон шалтгаан юу бэ?.....	35
График 16. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцаа үзүүлэх болсон шалтгаан юу бэ?, үйлчлүүлэгчдийн төрлөөр.....	35
График 17. ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр.....	36
График 18. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор.....	40
График 19. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр.....	40
График 20. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор.....	41
График 21. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр.....	41
График 22. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан.....	42
График 23. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ.....	43
График 24. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд.....	43
График 25. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд үзүүлэлтээр, дүүрэг тус бүрээр.....	44
График 26. БОҮ, оноогоор, байгууллагын төрлөөр.....	45
График 27. БОҮ, оноогоор, дэд үзүүлэлтээр.....	50
График 28. БОҮ, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр.....	50
График 29. Дүүргүүдийн ЗДТГ-ын БОҮ.....	52
График 30. Дүүргүүдийн ЗДТГ-ын БОҮ, дэд үзүүлэлтээр.....	52
График 31. Дүүргийн ЗДТГ-ын БОҮ, дэд үзүүлэлтээр, байршлаар.....	53
График 32. Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, оноор, нийт оролцогчдын хувьд.....	54

График 33. Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, судалгаанд оролцогчдын төрлөөр, оноор	55
График 34. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, иргэд ААНБ	59
График 35. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, төрийн албан хаагчид.....	60
График 36. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, бодлогод оролцогч шинжээчид ...	61
График 37. Авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд та юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?, албан хаагчдын хувьд	64
График 38. Бодлогод оролцогчдын үзэж байгаагаар авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлс.....	65
График 39. Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл, оноор, нийт оролцогчдын хувьд	66
График 40. Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл, судалгаанд оролцогчдын төрлөөр, оноор.....	67
График 41. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, оноор	68
График 42. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, судалгаанд оролцогчдын төрлөөр, оноор	68
Зураг 1. Үнэлгээний арга зүйн загвар.....	14
Зураг 2. Мэдээлэл цуглуулах үе шат	18
Зураг 3. Хяналтын үе шатууд	18
Зураг 4. Шударга байдлын үнэлгээний судалгаанд баримталсан зарчим.....	18
Зураг 5. Шударга байдлын үнэлгээ - 2023	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АТГ	Авлигатай тэмцэх газар
БОУ	Бодлогод оролцогчдын үнэлгээ
ГШБҮ	Гадаад шударга байдлын үнэлгээ
ДШБҮ	Дотоод шударга байдлыг үнэлгээ
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МЦБХ	Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын хэлтэс
ШБҮ	Шударга байдлын үнэлгээ
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

“Авлига” гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;

“Шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээг;

“Шударга байдлын үнэлгээний судалгаа” гэж гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээг хийхээр зохион байгуулж буй судалгааны нийлбэр цогцыг;

“Гадаад шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан, иргэд, ААНБ-ын төлөөллийн өгч буй үнэлгээг;

“Дотоод шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй нийтлэг үнэлгээг;

“Бодлогод оролцогчдын үнэлгээ” гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг;

“Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ” гэж АТГ-ын даргын 2015 он 09 дүгээр сарын 1-ний өдрийн А/88 дугаар тушаалын дагуу тооцож буй үнэлгээг ойлгох бөгөөд хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноогоор тус тус үнэлнэ.

“Төрийн үйлчилгээ” гэж төрийн байгууллага, төрийн албан хаагчаас хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд иргэд, бусад байгууллагад үзүүлж буй аливаа үйлчилгээг тус ойлгох юм.

Шударга байдлын үнэлгээний судалгааг асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, тайланг боловсруулах ажлыг “Эс Ай Си Эй” ХХК 2023 оны 05-11 дүгээр сарын хооронд гүйцэтгэлээ.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ)-д оролцогчдыг насны бүлгээр авч үзэхэд 2.6 хувийг 18-20 насныхан, 14.2 хувийг 20-29 насныхан, 29.0 хувийг 30-39 насныхан, 30.3 хувийг 40-49 насныхан, 17.8 хувийг 50-59 насныхан, 6.1 хувийг 60-аас дээш насныхны төлөөлөл байлаа. Харин нийт судалгаанд оролцогчдыг хүйсээр ангилан авч үзвэл 47.3 хувийг эрэгтэй, 52.7 хувь эмэгтэй оролцогчид эзэлж байв.

Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ)-д 2,645 төрийн албан хаагч хамрагдсан бөгөөд тэдгээрийн 25.0 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 39.5 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 35.5 хувь нь аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын төлөөлөл байсан. Албан хаагчдын ажилласан жилийн ангиллын хамгийн их хувийг буюу 42.8 хувийг 5 хүртэл жил ажилласан албан хаагчид, 22.9 хувийг 5-10 жил ажилласан албан хаагчид, 25.0 хувийг 10-20 жил ажилласан албан хаагчид, 9.3 хувийг 20-оос дээш жил ажилласан албан хаагчид эзэлж байв.

Бодлогод оролцогчдын үнэлгээ (БОҮ)-д нийт 1,940 оролцогч хамрагдсанаас 40.1 хувийг төрийн албан хаагч, 15.2 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 25.2 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 4.0 хувийг аудитор, хяналтын ажилтан, 6.6 хувийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.3 хувийг эрдэмтэн судлаач, 4.1 хувийг бодлого боловсруулагч, 0.6 хувийг бусад салбарын төлөөлөл тус тус эзэлж байв.

Шударга байдлын үнэлгээ

Энэ удаагийн судалгааны үр дүнгээр Шударга байдлын үнэлгээ 76.6 оноогоор үнэлэгдэж өмнөх оны үнэлгээний дүнгээс 2.7 оноогоор нэмэгджээ.

Шударга байдлын үнэлгээ ийнхүү 2.7 оноогоор нэмэгдэхэд гадаад шударга байдлын үнэлгээ 2.3 оноогоор, бодлогод оролцогчдын үнэлгээ 4.7 оноогоор сайжирсан нь ихээхэн нөлөөлсөн байв. Судалгааны үр дүнгээс үзэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд төрийн үйлчилгээ иргэдэд тэгш, хүртээмжтэй хүрэхэд ахиц дэвшил гарчээ.

ШБҮ-ний 2023 оны дүнг 2015 онтой харьцуулахад 2.8, 2016 онтой харьцуулахад 6.9, 2018 онтой харьцуулахад 7.9, 2019 онтой харьцуулахад 2.5, 2021 онтой харьцуулахад 3.4, 2022 онтой харьцуулахад 2.7 оноогоор тус тус өссөн байв.

Гадаад шударга байдлын үнэлгээ

2023 оны хувьд төрийн байгууллагуудын ГШБҮ нь 72.8 болж 2022 онтой харьцуулахад 2.3 оноогоор өсжээ. ГШБҮ-г төрийн байгууллагуудаар ангилан авч үзвэл Засгийн газрын агентлагуудын үнэлгээ нь аймаг, нийслэлийн ЗДТГ болон яамдын үнэлгээнээс өндөр байгаа нь 2023 онд Засгийн газрын агентлагууд бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад харьцангуй шударга ажилласан гэж хэлж болохоор байна.

Харин 2023 оны үнэлгээг 2022 оны үзүүлэлттэй харьцуулахад яамдын үнэлгээ 0.8 оноогоор, агентлагуудын үнэлгээ 4.0 оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 0.9 оноогоор тус тус өсжээ. Агентлагуудын үнэлгээ ШБҮ-ний дундажтай тэнцүү байгаа бол,

аймаг, нийслэлийн ЗДТГ, яамдын үнэлгээ доогуур байгаа нь яам болон ЗДТГ-ын үйлчилгээ шударга бус байсан гэдгийг харуулж байна.

Дотоод шударга байдлын үнэлгээ

2023 онд төрийн байгууллагуудын ДШБҮ 83.4 болж өмнөх онтой харьцуулахад 1.2 оноогоор нэмэгдсэн бөгөөд энэ нь 2018 оноос хойш тасралтгүй өсөж буй үр дүн юм.

ДШБҮ-г төрийн байгууллагын төрлөөр авч үзвэл яам бүх түвшинд үнэлгээ нь өссөн байдалтай байлаа.

ДШБҮ-г тооцоход ашигласан эхний үзүүлэлт бол соёлын индекс юм. Соёлын индексийг тооцоходоо албан бус хэм хэмжээ болон авлигын эсрэг тогтолцоо гэсэн хоёр дэд үзүүлэлтийг ашигласан. Судалгааны үр дүнгээс үзэхэд соёлын индекс 76.2 болж өмнөх оноос 1.2 оноогоор нэмэгджээ.

ДШБҮ-г тооцоход ашигласан сүүлийн үзүүлэлт нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс юм. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хүний нөөц, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, удирдлагын хүсэл, эрмэлзэл зэрэг 5 бүлгийн нэгж үзүүлэлтүүдээс хамаарч байна. Уг индексийг 2022 онтой харьцуулахад 1.1 оноогоор нэмэгджээ.

Бодлогод оролцогчдын үнэлгээ

БОУ-ний 2023 оны дүн 73.7 болж 2022 онтой харьцуулахад 4.7 оноогоор өсжээ. Ийнхүү өсөхөд БОУ-д оролцогчдын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг өссөн хэмээн үнэлснээс шалтгаалсан байна.

Яамдын БОУ-ний дундаж 77.3 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 10.2 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт юм. 2015-2022 оны дүнгээс харахад яамдын БОУ 2019 онд 4.5 оноогоор нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлт байсан бол энэ жилийн хувьд дээд өсөлтийг үзүүлжээ.

Авлигыг хянах механизмд өгч буй үнэлгээ хамгийн бага буюу 56.5 байв. Энэ үзүүлэлт БОУ-ний дунджаас 17.2 оноогоор бага байна. Үнэлгээг 2022 онтой харьцуулахад 8.5 оноогоор өсчээ.

Авлигын бодит тохиолдолд өгсөн үнэлгээ 97.5 байгаа нь 2022 онтой харьцуулахад 3.2 оноогоор өссөн байна.

БОУ-ний судалгаанд оролцогчдын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 76.4 болж 2022 онтой харьцуулахад 2.7 оноогоор нэмэгджээ.

Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлд өгсөн үнэлгээ 64.4 байгаа нь 2022 онтой харьцуулахад 4.6 оноогоор өссөн байна.

Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 49.6 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэж хариулжээ. Энэ нь 2022 онтой харьцуулахад 2.9 оноогоор нэмэгджээ.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад дийлэнх нь “Шүүх” гэж хариулжээ. Үүний дараа Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага, Гаалийн байгууллага эрэмбэлэгдэж байна. Энэхүү үр дүнг 2022 онтой харьцуулахад эрэмбэ нь төдийлөн өөрчлөгдөөгүй байгаагаас үзэхэд эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна. Мөн судалгааны үр дүнг дүгнэн

үзэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд эдгээр байгууллагуудад бий болсон авлигыг бууруулах чиглэлд ахиц гарсан ажил хийгдээгүй гэж үзэхээр байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад 25.7 хувь нь цалин хөлсний хэмжээ бага, амьжиргааны түвшин доогуур, 15.5 хувь нь хууль эрхзүйн хэрэгжилт сул, 11.7 хувь хүнд суртал, 11.6 хувь нь хүмүүсийн ухамсар хандлагаас шалтгаалж байна гэж хариулжээ.

Судалгаанд оролцсон 10 оролцогч тутмын 3 нь ирэх 2 жилийн хугацаанд Монгол Улсад авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй хэмээсэн бол, 3 нь буурна, 2 нь өснө гэж үзжээ. Сүүлийн 2 жилийн хугацаанд Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал буурна гэж үзсэн хүмүүсийн тоо өснө гэж үзсэн хүмүүсийн тооноос илүү байгаа нь АТГ-ын өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа үр дүнтэй байсан гэдгийг илтгэж байна.

Судалгаанд оролцогчдоор АТГ-ын үйл ажиллагааг үнэлүүлэхэд 10 оролцогч тутмын 4 нь АТГ-ын үйл ажиллагааг дунд зэрэг хэмээн үнэлсэн бол 3 нь үр ашигтай, 2 нь үр ашиггүй, үлдсэн 1 нь мэдэхгүй гэж хариулжээ. АТГ-ын үйл ажиллагааг үр ашигтай гэж үзэж буй хүмүүсийн тоо үр ашиггүй гэж үзсэн хүмүүсийн тооноос илүү байгаа нь сүүлийн нэг жилийн хугацаанд АТГ-ын хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаа үр бүтээлтэй байсныг харуулж байна.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү бүлэгт судалгааны ажлын зорилго, зорилт, ашигласан арга зүй, хамрах хүрээ, түүвэр, түүврийн хуваарилалт, судалгааны зохион байгуулалт болон судалгааг хийхэд баримталсан зарчмын талаар орууллаа.

1.1. Зорилго, зорилт

Шударга байдлын үнэлгээний судалгааны асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, тайланг боловсруулан үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг гүйцэтгэх нь энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын үндсэн зорилго байсан.

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- ✓ Шударга ёсыг бэхжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах;
- ✓ Тухайн байгууллагын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох;
- ✓ Үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилга өрнүүлэх, эрмэлзлийг бий болгох;

1.2. Арга зүйн загвар, үнэлгээний утга

1.2.1. Үнэлгээний утга

Шударга байдлын үнэлгээг **0-100** хүртэлх оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга **100-тай** тэнцүү бол **хамгийн шударгыг** илэрхийлнэ.

1.2.2. Үнэлгээний загвар

Шударга байдлын үнэлгээг дараах зурагт харуулсан арга зүйн загварын дагуу гүйцэтгэсэн болно.

Зураг 1. Үнэлгээний арга зүйн загвар



1.2.3. Үнэлгээг тооцох арга

- Шударга байдлын үнэлгээний үр дүнг байгууллага бүрийн болон улсын дүнгээр гаргана.
- Шударга байдлын үнэлгээг 0-100 хүртэл оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлнэ.
- Шударга байдлын үнэлгээ болон түүнийг бүрдүүлэгч үнэлгээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцно.

Гадаад шударга байдлын үнэлгээ

$$E_i = (A_i + B_i + C_i) / 3$$

E_i – i байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

A_i – Авлигын индексийн оноо

B_i – Ил тод байдлын индексийн оноо

C_i – Хариуцлагатай байдлын оноо

Дотоод шударга байдлын үнэлгээ

$$I_i = (A_i + B_i) / 2$$

I_i – i байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ

A_i – Соёлын индексийн оноо

B_i – Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын оноо

Бодлогод оролцогчдын үнэлгээ

$$P_i = (A_i + B_i + C_i) / 3$$

- P_i – Байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ
- A_i – Авлигын талаарх төсөөллийн оноо
- B_i – Авлигын хяналтын оноо
- C_j – Авлигын бодит тохиолдлын оноо

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ

K_i = Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, (АТГ-ын даргын 2015 он 09 дүгээр сарын 1-ний өдрийн А/88 дугаар тушаалын дагуу тооцно)

Байгууллагын ерөнхий үнэлгээг тооцох томьёо

$$J_i = (E_i + I_i + P_j + K_i) / 4$$

J_i - Байгууллагын шударга байдлын үнэлгээ

D. Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулах бөгөөд үзүүлэлтийг хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсхүл байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах гэсэн 2 аргын аль тохирохыг ашиглана.

1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шилжүүлэх

1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэхдээ дараах загварыг баримтална. Тухайн хариулт эерэг утгатай бол 100 оноог, сөрөг утгатай бол 0 оноог өгөх зарчмыг баримтална.

Хүснэгт 1. Хэмжээст утгад шилжүүлэх загвар

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100 оноо
Түгээмэл	2	25 эсвэл 75 оноо
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25 оноо
Огт байхгүй	5	100 эсвэл 0 оноо

Үзүүлэлтийн дундаж оноог тооцох

Тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцоход дараах томьёог ашиглана.

$$\text{Үзүүлэлтүүдийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн судалгаанд хамрагдсан нийт хүний тоо}}$$

E. Байгууллагын үнэлгээгээр тооцох

Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах

Байгууллага бүрийн давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулахад тухайн хариултын интервалыг нэг үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай ба дараах байдлаар шилжүүлнэ.

Хүснэгт 2. Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах

Төрөл	Давтамж болон үнийн дүн			
Дотоод шударга байдал	Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий эд зүйлс өгсөн тохиолдлын давтамжийг оноожуулах <i>1 удаа=1 2 удаа=2 3 удаа=3 4-5 удаа=4.5 6-10 удаа=8 11 ба түүнээс дээш удаа=11</i>	Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, дүр үнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий эд зүйлсийн үнийн дүнг оноожуулах <i>20000₮=20 21000-50000₮=35 51000-100000₮=77 101000-300000₮=205 301000-500000₮=405 501000-1 сая₮=755 1.1-2.0 сая₮=1550 2.1-5.0 сая₮=3550 5.1-10 сая₮=7550 10.1 сая₮-өөс дээш=10100</i>	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах байдлын үнийн дүнг оноожуулах <i>200,000₮ хуртэл=200 201,000-500,000₮=355 501,000-1 сая₮=775 1.1-3.0 сая₮=2050 3.1-5.0 сая₮=4050 5.1-10.0 сая₮=7550 10.1-20.0 сая₮=15050 20.1-50.0 сая₮=35050 50.1-100 сая₮=75050 110.1 сая₮-өөс дээш=110100</i>	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/хууль бус үүрэг даалгавар өгөх явдлын давтамжийг оноожуулах <i>Жилд 1 удаа=1 Жилд 2-3 удаа=2.5 Улиралд 1 удаа=4 Сард 1 удаа=12 Сард 2 удаа=24 Сард 3 болон түүнээс дээш=48</i>
Гадаад шударга байдал	Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх, хандив бусад санхүүгийн туслалцаа өгөх байдлыг оноожуулах <i>1 удаа=1 Хоёр удаа=2 Гурван удаа=3 4-5 удаа=4.5 6-7 удаа=6.5 8-9 удаа=8.5 10-аас дээш удаа=10</i>	Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх, хандив бусад санхүүгийн туслалцаа өгөх байдлын дүнг оноожуулах <i>20000₮=20 21000-50000₮=35 51000-100000₮=77 101000-300000₮=205 301000-500000₮=405 501000-1 сая₮=755 1.1-2.0 сая₮=1550 2.1-5.0 сая₮=3550 5.1-10 сая₮=7550 10.1 сая₮-өөс дээш=10100</i>		
Дунджийг тооцох	Тухайн байгууллагын давтамж, үнийн дүнгийн онооны нийлбэрт үндэслэн тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан нэг хүнд оногдох давтамж, үнийн дүнгийн онооны дунджийг дараах томъёогоор олно. Нэг хүнд оногдох давтамж, үнийн дүнгийн онооны дундаж = $\frac{\text{Онооны нийлбэр}}{\text{Судалгаанд хамрагдсан нийт хүн}}$			
Оноожуулах	Дунджид үндэслэн бусад байгууллагатай жиших замаар байгууллагын давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийг оноожуулах бөгөөд дараах томъёогоор олно. <i>Давтамж үнийн дүн бүхий үзүүлэлтүүдийн оноо=100*(1-Тухайн байгууллагын давтамж(үнийн дүн)-ийн дундаж/UCP)</i> USP1= бүх байгууллагын давтамж, үнийн дүнгийн дунджаас тооцсон өсөн нэмэгдэх гамма тархалтын 95%-тай тэнцүү утга буюу тухайн жилд хамгийн өндөр давтамж, үнийн дүн бүхий байгууллагын дундаж			

Г. Нийт шударга байдлын үнэлгээг тооцох

Судалгаанд хамрагдсан бүх төрийн байгууллагын шударга байдалд үндэслэн тухайн оны шударга байдлын үнэлгээг гаргах бөгөөд дараах томъёог ашиглана.

$$\text{Шударга байдлын үнэлгээ} = \frac{X_1 + X_2 + \dots + X_i + \dots + X_n}{n}$$

X_i – i дугаар байгууллагын шударга байдлын үнэлгээ

n – судалгаанд хамрагдсан байгууллагын тоо

1.3. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаанд зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага буюу яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг хамруулсан. Энэ удаагийн судалгаанд дүүргүүдийн ЗДТГ-ыг хамруулсан нь онцлог байсан. ШБҮ-г тооцох 2022 оны судалгаанд **80 байгууллага** (яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ)-ыг хамруулсан.

1.4. Түүврийн хэмжээ

Энэхүү судалгаанд төрийн үйлчилгээ авсан иргэд, ААНБ, төрийн байгууллагын албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчдээс бүрдсэн **15,405** судалгааны нэгжийг хамрууллаа. Дараах хүснэгтэд түүврийн хуваарилалтыг оролцогчдын төрлөөр харууллаа. Түүврийн дэлгэрэнгүй хуваарилалтыг “Хавсралт 1”-ээс харах боломжтой.

Хүснэгт 3. Түүврийн хэмжээ

№	Төлөөлөл	Түүврийн нэгжийн тоо	Асуулгын хуудасны төрөл	Үнэлгээний төрөл
1	Төрийн үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл	10,780	Асуулга 1	ГШБҮ
2	Төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчид	2,645	Асуулга 2	ДШБҮ
3	Бодлогод оролцогчид	1,980	Асуулга 3	БОҮ
Нийт түүврийн хэмжээ		15,405	-	-

1.5. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт


Судалгааг АТГ-аас нэгдсэн удирдамжаар хангаж ажилласан бөгөөд мэдээлэл цуглуулах, тооцоолол хийх, тайлан боловсруулах үйл ажиллагааг судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК гүйцэтгэсэн.

Мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл нийт 104 хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулалтын багт Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 30 ажилтан ажилласан.

Мэдээлэл цуглуулалт явагдаж байх хугацаанд “Үндэсний их баяр наадам”-ын болон төрийн байгууллагын албан хаагчдын амралт давхацсан нь мэдээлэл цуглуулах ажлыг удаашрахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн.


Мэдээлэл цуглуулах багийн ажилчид дараах 3 үе шатын дагуу төлөвлөгөө гарган ажилласан ба дараах зурагт схемчлэн харууллаа.

Зураг 2. Мэдээлэл цуглуулах үе шат



Уг судалгаанд **сургалтын** болон **мэдээлэл шивэлтийн** гэсэн 2 төрлийн хяналтыг хийсэн. Мөн долоо хоног бүр захиалагчид явцын мэдээлэл илгээж байсан нь тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг цаг тухай бүрд нь шийдвэрлэхэд тусалж байв.

Зураг 3. Хяналтын үе шатууд



1.6. Судалгааг хийхэд баримталсан зарчим

Бид судалгааны ажлыг гүйцэтгэх явцдаа дараах зарчмыг баримтлан ажилласан.

Зураг 4. Шударга байдлын үнэлгээний судалгаанд баримталсан зарчим



БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү бүлэгт судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг оролцогчдын төрөл тус бүрээр орууллаа.

2.1 Иргэн/хувь хүн, ААНБ-ын төлөөлөл

Гадаад шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөллийг хамруулдаг. 2023 оны Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд нийт 10780 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдсан бөгөөд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төлөөлсөн хүмүүсийн 79.5 хувийг хувь хүн, 20.5 хувийг аж ахуй нэгж, байгууллага бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

ДД	Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нийт			10,780	100.0
1	Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ хэнийг төлөөлсөн бэ?	Хувь хүн	8575	79.5%
		Аж ахуйн нэгж байгууллага	2205	20.5%
2	Судалгаанд оролцогчдын нас	20 хүртэл	280	2.6%
		20-29	1534	14.2%
		30-39	3125	29.0%
		40-49	3265	30.3%
		50-59	1916	17.8%
		60-аас дээш	660	6.1%
3	Судалгаанд оролцогчдын хүйс	Эрэгтэй	5094	47.3%
		Эмэгтэй	5686	52.7%

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзэхэд 2.6 хувийг 18-20 насныхан, 14.2 хувийг 20-29 насныхан, 29.0 хувийг 30-39 насныхан, 30.3 хувийг 40-49 насныхан, 17.8 хувийг 50-59 насныхан, 6.1 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байв.

Харин нийт судалгаанд оролцогчдыг хүйсээр ангилан авч үзвэл 47.3 хувийг эрэгтэй, 52.7 хувь эмэгтэй оролцогчид эзэлж байв.

2.2. Албан хаагчдын төлөөлөл

ДШБҮ-д хамрагдсан албан хаагчдын 25.0 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 39.5 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 35.5 хувь нь аймаг нийслэлийн ЗДТГ-ын төлөөлөл байсан. Албан хаагчдын ажилласан жилийн ангиллын хамгийн их хувийг буюу 42.8 хувийг 5 хүртэл жил ажилласан албан хаагчид эзэлж байв.

Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

№	Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нийт			2,645	100.0
1	Таны ажиллаж буй байгууллагын ангилал?	Төрийн захиргааны төв байгууллага буюу яам	660	25.0
		Төрийн захиргааны байгууллага буюу агентлаг	1,045	39.5
		Засаг даргын Тамгын газар	940	35.5
2	Та энэ салбар байгууллагад нийтдээ хэдэн жил ажиллаж байна вэ?	5 хүртэл жил	1,131	42.8
		5-10 жил	607	22.9
		10-20 жил	660	25.0
		20-оос дээш жил	247	9.3

2.3. Бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөлөл

БОУ-д нийт 1,980 оролцогч хамрагдсанаас 34.5 хувийг төрийн албан хаагч, 14.8 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 24.5 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.8 хувийг аудитор, хяналтын ажилтан, 6.3 хувийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 7.6 хувийг эрдэмтэн судлаач, 4.1 хувийг бодлого боловсруулагч, 0.4 хувийг бусад салбарын төлөөлөл тус тус эзэлж байв.

Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

ДД	Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нийт			1,980	100.0
1	Шинжээчийн төлөөлж буй хүрээ	Төрийн албан хаагч	684	34.5
		Төрийн бус байгууллага	293	14.8
		Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл	486	24.5
		Аудитор, хяналтын ажилтан	155	7.8
		Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч	124	6.3
		Эрдэмтэн, судлаач	150	7.6
		Бодлого боловсруулагч	81	4.1
		Бусад	7	0.4

БҮЛЭГ 3. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Энэ бүлэгт шударга байдлын үнэлгээний (ШБҮ) нэгдсэн үр дүн болон гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ), дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ), бодлогод оролцогчдын үнэлгээний (БОУ) үр дүнг тус тус орууллаа.

3.1. Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн

3.1.1. ШБҮ-ний ерөнхий дүн

ШБҮ-г тооцохдоо АТГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг ашигласан. Тодруулбал төрийн үйлчилгээг авсан иргэд, ААНБ, төрийн үйлчилгээг хүргэж буй албан хаагчид, бодлогод оролцогчдын үнэлгээний дунджаар тооцсон болно. Тооцоололд нийт 62 нэгж үзүүлэлтүүдийг хамруулан авч үзлээ.


Энэ удаагийн судалгааны үр дүнгээр Шударга байдлын үнэлгээ 76.6 оноогоор үнэлэгдэж өмнөх оны үнэлгээний дүнгээс 2.7 оноогоор нэмэгджээ.

Шударга байдлын үнэлгээ ийнхүү 1.0 оноогоор нэмэгдэхэд гадаад шударга байдлын үнэлгээ болон дотоод шударга байдлын үнэлгээ сайжирсан нь ихээхэн нөлөөлсөн байв. Өмнөх судалгааны үр дүнгээс үзэхэд (ШБҮ-2021) гадаад шударга байдлын үнэлгээ буурсан нь нэгдсэн үнэлгээ буурахад нөлөөлж байсан бол энэ удаа сайжирч, өнгөрсөн нэг жилийн хугацаанд төрийн үйлчилгээ иргэдэд тэгш, хүртээмжтэй хүрэхэд ахиц дэвшил гарсныг харуулсан сайшаалтай үр дүн юм.

Зураг 5. Шударга байдлын үнэлгээ - 2023




График 1. Шударга байдлын үнэлгээ, оноогоор



ШБҮ-ний 2023 оны дүнг 2015 онтой харьцуулахад 2.8 , 2016 онтой харьцуулахад 6.9, 2022 онтой харьцуулахад 2.7 оноогоор тус тус өссөн бөгөөд өмнөх онуудаас хамгийн өндөр оноотой байна.


График 2. ШБҮ, оролцогчдын төрлөөр, оноор



Үнэлгээ тус бүрийг өмнөх онтой харьцуулбал ГШБҮ 2.3 оноогоор, ДШБҮ 1.2 оноогоор, БОҮ 4.7 оноогоор тус тус өсжээ. ГШБҮ 2.3 оноогоор нэмэгдэхэд ил тод байдал, хариуцлагатай байдлын үнэлгээ сайжирсан нь нөлөөлсөн байв. ДШБҮ 2018 оноос хойш тасралтгүй өсөлттэй байгаа бөгөөд ШБҮ-ний дунджаас 6.8 оноогоор өндөр байна.

Харин БОҮ 2016 оноос хойш тасралтгүй өссөн бөгөөд дундаж үнэлгээнээс 2.9 оноогоор бага байлаа. Ийнхүү буурсан нь авлигыг хянах механизм сул байсан, авлигын бодит тохиолдол нэмэгдсэн, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл буурснаас шалтгаалсан байв.

График 3. ШБҮ, байгууллагаар, оноор



Судалгааны үр дүнг 2022 онтой харьцуулахад яамдын үнэлгээ 5.0 оноогоор, агентлагуудын үнэлгээ 2.8 оноогоор, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 1.6 оноогоор тус тус өссөн байв. Яам болон агентлагуудын үнэлгээ дундаж үнэлгээнээс илүү байгаа бол аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ бага байлаа.

ШБҮ 2023 оны судалгаагаар оролцогчдын хамгийн шударга хэмээн үнэлсэн байгууллага “Стандарт хэмжил зүйн газар” байв. Тухайн байгууллага 2022 онд 79.3 оноогоор үнэлэгдэж арван хоёрдугаар байрт эрэмбэлэгдэж байсан бол энэ удаа 9.4 оноогоор үнэлгээгээ сайжруулж нэгдүгээрт эрэмбэлэгджээ. “Боловсролын ерөнхий газар”-ын үнэлгээ нь өмнө жилийхээс 14.2 оноогоор өссөн буюу хамгийн их өсөлтийг үзүүлсэн байна.

Харин “Биеийн тамир, спортын улсын хороо” хамгийн бага оноогоор үнэлэгдсэн байна. Төв аймгийн ЗДТГ нь өмнө жил дөрөвдүгээр байрт эрэмбэлэгдэж байсан бол энэ жил хамгийн их буюу 13.5 оноогоор буурч далан дөрөвдүгээр байрт эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 7. ШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2022 оны эрэмбэ	2023 оны эрэмбэ	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Стандарт, хэмжил зүйн газар	12	1	79.3	88.7	9.4
2	Гадаадын иргэн, харьяатын газар	7	2	77.7	87.5	9.8
3	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	20	3	78.2	85.6	7.4
4	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-	4	-	85.2	-
5	Боловсролын ерөнхий газар	61	5	70.5	84.7	14.2
6	Жижиг, дунд үйлдвэрийн газар	1	6	88.0	83.9	-4.1
7	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	46	7	72.9	83.7	10.8
8	Төрийн худалдан авах ажиллагааны газар	8	8	79.6	83.5	3.9
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	16	9	78.8	82.9	4.1
10	Батлан хамгаалах яам	6	10	80.5	82.9	2.4
Хамгийн бага үнэлгээтэй:						
71	Нийгмийн даатгалын ерөнхий газар	2	71	82.3	69.5	-12.8
72	Завхан аймгийн ЗДТГ	10	72	79.5	69.3	-10.2
73	Хэнтий аймгийн ЗДТГ	34	73	75.0	69.0	-6.0
74	Төв аймгийн ЗДТГ	4	74	81.6	68.1	-13.5
75	Ховд аймгийн ЗДТГ	74	75	64.6	67.5	2.9
76	Гаалийн ерөнхий газар	72	76	65.8	66.5	0.7
77	Увс аймгийн ЗДТГ	41	77	74.0	66.1	-7.9
78	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	76	78	63.0	65.7	2.7
79	Иргэний нисэхийн ерөнхий газар	32	79	75.1	64.7	-10.4
80	Биеийн тамир, спортын улсын хороо	63	80	69.9	63.3	-6.6

Яамдын үнэлгээг эрэмбэлэхэд дийлэнх нь буюу 11 яам улсын дунджаас дээгүүр, үлдсэн 5 нь улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна. Нийт ШБҮ-тэй харьцуулахад яамдын ШБҮ нь 1.8-р их байна.

“Эдийн засаг хөгжлийн яам”, “Соёлын яам” -с бусад бүх яамны ШБҮ өссөн үзүүлэлттэй гарсан байна.


График 4. Яамдын ШБҮ, 2023 он, оноогоор



Агентлагуудын үнэлгээ 2022 онтой харьцуулахад 4.1 оноогоор сайжирсан ба нийт 33 агентлаг судалгаанд хамрагдсанаас 22 агентлагийн үнэлгээ дунджаас дээгүүр, 11 агентлагийнх дунджаас доогуур түвшинд байна.

Хамгийн өндөр үнэлгээг “Стандарт хэмжил зүйн газар” авсан бол, хамгийн бага үнэлгээг “Биеийн тамир спортын газар” авчээ. Түүнчлэн 4 агентлагийн үнэлгээ өмнөх жилээс буурсан дүнтэй байгаа бол 29 агентлагийнх өссөн, 1 агентлаг шинээр нэмэгдсэн байлаа.

График 5. Агентлагуудын ШБҮ, 2023 он, оноогоор



Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын 4 нь улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа нь өнгөрсөн жилээс таваар бага, 18 нь доогуур үнэлгээ авсан нь өнгөрсөн жилээс таваар илүү үр дүн байв. Үнэлгээг 2022 онтой харьцуулахад 17 байгууллагынх сайжирсан, харин үлдсэн 5 байгууллагынх буурсан байв. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 2022 онтой харьцуулахад 10.6 оноогоор нэмэгдэж хамгийн өндөр үнэлгээ авсан төдийгүй нийт байгууллагуудын хувьд нэгдүгээрт эрэмбэлэгдэж байна. Харин Баян-Өлгий аймгийн ЗДТГ хамгийн бага оноог авсан байна.


График 6. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ, 2023 он, оноогоор



3.2.2. Дүүргүүдийн ЗДТГ-ын ШБҮ

Энэ удаагийн судалгаагаар нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ хамрагдсан бөгөөд “Сүхбаатар дүүргийн ЗДТГ” хамгийн өндөр үнэлгээг авсан бол “Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ” хамгийн бага үнэлгээг авчээ. Дүүргүүдээс 5 нь дундаж үнэлгээнээс дээгүүр түвшинд үнэлэгдсэн бол үлдсэн 4 нь дунджаас доогуур үнэлэгджээ.

График 7. Дүүргүүдийн ЗДТГ-ын 2023 оны ШБҮ



3.2. Гадаад байдлын үнэлгээний ерөнхий үр дүн


Төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, ААНБ-ын төлөөллөөс ГШБҮ-ний судалгааг авсан. Энэхүү үнэлгээг ил тод, хариуцлагатай байдлын индекс, авлигын индексийн дунджаар тооцсон болно. Уг 2 дэд үзүүлэлтийн дунджийг тооцоход 5 бүлгийн 20 нэгж үзүүлэлтийг ашигласан.

3.2.1. Гадаад шударга байдлын ерөнхий үр дүн

Гадаад шударга байдлын ерөнхий үр дүнд төрийн үйлчилгээ үзүүлдэг яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд хамрагдсан.

2023 оны хувьд ЗГ-ын агентлагуудын ГШБҮ 76.6 болж 2022 онтой харьцуулахад 4 оноогоор, 2021 онтой харьцуулахад 10.1 оноогоор өссөн байна. Энэхүү өсөлтөд 2022 онд 78.4 үнэлгээтэй байсан авлигын индекс 2023 онд 85.3 болж 6.9 оноогоор өссөн нь хамгийн их нөлөөг үзүүлжээ. Харин улсын хэмжээнд 2023 онд авлигын индекс 5.2-оор өссөн ба үүний үр дүнд ГШБҮ 72.8 оноо авч 2021 онтой харьцуулахад 2.3-аар өсжээ. 2021 оноос хойш ЗДТГ-ууд, Яамдууд, Төрийн байгууллагуудын ГШБҮ жил бүр өссөн болохыг дараах графикаас харах боломжтой.

График 8. ГШБҮ, оноор, байгууллагын төрлөөр, оноогоор



2023 оны хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээтэй 5 төрийн байгууллагын өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Төрийн байгууллагуудын 2023 оны ГШБҮ-ний хэлбэлзлийг авч үзвэл 56.1-93.6 онооны хооронд байсан ба Стандарт, хэмжил зүйн газар 2022 оны үнэлгээгээ 9.2-оор

ахиулан улсын хэмжээнд хамгийн өндөр үнэлгээг авсан бол Орхон аймгийн ЗДТГ хамгийн бага буюу 49.7 үнэлгээг авчээ.

Өөрчлөлтийн хувьд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 25.6-аар хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бол 2022 онд хамгийн өндөр үнэлгээтэй байсан Төв аймгийн ЗДТГ-ын ГШБҮ 31.4-өөр буурч хамгийн өндөр уналтыг үзүүлжээ. Энэхүү бууралтад авлигын шууд бус тохиолдол 26.82, авлигын шууд тохиолдол 25.72, байгууллагын ил тод байдал 38.12, авлигын талаарх төсөөлөл 36.03, байгууллагын хариуцлагатай байдал 28.56-гаар буурсан нь ихээхэн нөлөөлжээ.

Хүснэгт 8. ГШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:				
1	Стандарт, хэмжил зүйн газар	84.4	93.6	9.2
2	Гадаадын иргэн, харьяатын газар	83.9	87.6	3.7
3	Цаг уур, орчны шинжилгээний газар	74.4	87.4	13.0
4	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-	87.0	-
5	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	59.9	85.5	25.6
Хамгийн бага үнэлгээтэй:				
67	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	75.9	58.9	-17.0
68	Биеийн тамир, спортын улсын хороо	64.9	56.1	-8.8
69	Төв аймгийн ЗДТГ	86.5	55.1	-31.4
70	Увс аймгийн ЗДТГ	59.8	55.1	-4.7
71	Орхон аймгийн ЗДТГ	72.2	49.7	-22.5

Судалгаанд хамрагдсан 16 яамдын ГШБҮ-ний дундаж үнэлгээ өмнөх оноос 0.8 оноогоор өссөн ба эдгээр 16 яам тус бүрийн үнэлгээг 2022 онтой харьцуулахад 6 яамдын үнэлгээ буурч 10 яамны үнэлгээ нэмэгдсэн байна. Үнэлгээ сайжирсан яамдад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”, “Соёлын яам”, “Батлан хамгаалах яам”, “Гадаад харилцааны яам”, “Зам, тээврийн хөгжлийн яам”, “Эдийн засаг, хөгжлийн яам”, “Боловсрол, шинжлэх ухааны яам” “Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам”, “Барилга, хот байгууллын яам”, “Эрүүл мэндийн яам” зэрэг хамаарч байна. Үнэлгээний хувьд хамгийн өндөр бууралттай байгаа “Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам”-ын ил тод байдал өмнөх оноос 23.4, хариуцлагатай байдал 16, авлигын талаарх төсөөлөл 23.2, авлигын шууд тохиолдол 4.7, авлигын шууд бус тохиолдол 14.9 оноогоор буурсан ба энэ нь авлигын эрсдэлийн индекс 19.7, авлигын индекс 14.2-оор буурах улмаар ГШБҮ нь унах шалтгаан болжээ. Үүнээс харахад дээр дурдсан үзүүлэлтүүд дээрээ цаашид илүү анхаарч ажиллах шаардлагатай болохыг харуулж байна.

Яамдын ГШБҮ 83.7-58.9 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь 2022¹ онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 5.4, дээд түвшин 0.4-өөр сайжирсныг илэрхийлж байна.

Хүснэгт 9. Яамдын ГШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Яамдын ГШБҮ		73.3	74.1	0.8
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	82.0	83.7	1.7
2	Соёлын яам	78.0	81.6	3.6
3	Батлан хамгаалах яам	77.5	81.3	3.8
4	Гадаад харилцааны яам	79.3	80.7	1.4
5	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	79.5	79.4	-0.1
6	Зам, тээврийн хөгжлийн яам	68.1	78.0	9.9

¹ Яамдын ГШБҮ 2022 онд 83.3-53.05 хооронд хэлбэлзэж байв.

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
7	Эдийн засаг, хөгжлийн яам	72.7	75.5	2.8
8	Сангийн яам	77.0	74.5	-2.5
9	Боловсрол, шинжлэх ухааны яам	64.5	73.9	9.4
10	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам	69.1	73.7	4.6
11	Эрчим хүчний яам	74.7	73.3	-1.4
12	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	83.6	71.6	-12.0
13	Барилга, хот байгууллын яам	53.5	71.3	17.8
14	Эрүүл мэндийн яам	63.5	64.2	0.7
15	Хууль зүй, дотоод хэргийн яам	73.3	63.6	-9.7
16	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	75.9	58.9	-17.0

Судалгаанд хамрагдсан ЗГ-ын агентлагуудын ГШБҮ 2022 онтой харьцуулахад 4.0 оноогоор өссөн ба ерөнхий ГШБҮ-ээс 3.8-аар өндөр үнэлгээ авчээ. Эдгээр 33 байгууллагын 3 нь анх удаа ШБҮ-ний судалгаанд хамрагдаж байгаа билээ. 2022 онтой харьцуулахад 12 байгууллагын ГШБҮ буурсан байгаа бол үлдсэн 21 байгууллагынх өссөн байна. Үнэлгээ хамгийн их сайжирсан агентлагт “Боловсролын ерөнхий газар”, “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар”, “Улсын бүртгэлийн ерөнхий газар” зэрэг хамаарч байна.

Агентлагуудын ГШБҮ 56.1-93.6 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь 2022² онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 3.3, дээд түвшин 9.2 хувиар өссөнийг илэрхийлж байна. Өсөлтийн гол шалтгаанд авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 4.8 оноогоор, авлигын шууд тохиолдлын үнэлгээ 2.4 оноогоор, авлигын шууд бус тохиолдлын үнэлгээ 13.6 оноогоор тус бүр өссөн нь хамгийн их нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 10. Агентлагуудын ГШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Агентлагуудын ГШБҮ		72.6	76.6	4.0
1	Стандарт, хэмжил зүйн газар	84.4	93.6	9.2
2	Гадаадын иргэн, харьяатын газар	83.9	87.6	3.7
3	Цаг уур, орчны шинжилгээний газар	74.7	87.4	12.6
4	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-	87.0	-
5	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	59.9	85.5	25.6
6	Төрийн худалдан авах ажиллагааны газар	80.0	83.7	3.7
7	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	68.3	82.6	14.4
8	Оюуны өмчийн газар	83.0	82.4	-0.6
9	Архивын ерөнхий газар	83.3	82.4	-0.9
10	Боловсролын ерөнхий газар	52.8	82.2	29.4
11	Мал эмнэлгийн ерөнхий газар	72.0	82.1	10.1
12	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	76.2	81.1	4.9
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	69.2	80.8	11.6
14	Улсын бүртгэлийн ерөнхий газар	59.0	80.3	21.3
15	Жижиг, дунд үйлдвэрийн газар	81.3	79.1	-2.2
16	Онцгой байдлын ерөнхий газар	80.4	77.9	-2.5
17	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	76.2	77.4	1.2
18	Үндэсний геологийн алба	64.8	77.2	12.4
19	Ойн газар	-	77.1	-
20	Соёл, урлагийн газар	76.5	77.0	0.5
21	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар	-	76.1	76.1
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	67.2	76.1	8.8
23	Татварын ерөнхий газар	70.6	75.6	5.0
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	81.6	71.4	-10.2
25	Усны газар	83.7	70.7	-13.1

² Үнэлгээнд хамрагдсан агентлагуудын ГШБҮ 2022 онд 52.8-84.4 оноо авсан.

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
26	Ашигт малтмал, газрын тосны газар	68.4	70.5	2.1
27	Нийгмийн даатгалын ерөнхий газар	78.6	69.1	-9.5
28	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	63.4	66.8	3.3
29	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	81.4	65.8	-15.7
30	Цагдаагийн ерөнхий газар	73.3	65.1	-8.2
31	Гаалийн ерөнхий газар	63.9	60.8	-3.0
32	Иргэний нисэхийн ерөнхий газар	74.5	59.5	-15.0
33	Биеийн тамир, спортын улсын хороо	64.9	56.1	-8.7

Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ-ний дундаж үнэлгээ нь 2022 онтой харьцуулахад 0.9-ээр өссөн байна. Энэхүү үр дүн нь ерөнхий ГШБҮ-ээс 6.5 оноогоор бага, ШБҮ-ээс 10.3 оноогоор тааруу байгаа харагдаж байв. Мөн нийт судалгаанд хамрагдсан ЗДТГ-уудын ГШБҮ-г 2022 оны үр дүнтэй харьцуулахад 11 ЗДТГ-ын үнэлгээ сайжирсан, үлдсэн 11 нь буурсан байв. Үнэлгээ сайжирсан байгууллагуудад “Говьсүмбэр аймгийн ЗДТГ”, “Сэлэнгэ аймгийн ЗДТГ”, “Булган аймгийн ЗДТГ”, “Дундговь аймгийн ЗДТГ”, “Баянхонгор аймгийн ЗДТГ”, “Нийслэлийн ЗДТГ”, “Дархан-Уул аймгийн ЗДТГ” зэрэг хамаарч байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-дийн ГШБҮ-ээр Говьсүмбэр аймгийн ЗДТГ хамгийн өндөр өсөлтийг ба Төв аймгийн ЗДТГ хамгийн өндөр бууралтыг үзүүлжээ.

ЗДТГ-уудын ГШБҮ 49.7-82.2 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь 2022³ онтой харьцуулахад үнэлгээний доод түвшин 5.9-өөр нэмэгдэж, дээд түвшин 4.3 оноогоор буурсныг илэрхийлж байна.

Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-дийн ГШБҮ	65.4	66.3	0.9
1	Булган аймгийн ЗДТГ	63.3	82.2	18.9
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	52.4	78.9	26.5
3	Өвөрхангай аймгийн ЗДТГ	78.0	77.9	-0.1
4	Дорнод аймгийн ЗДТГ	59.5	71.5	11.9
5	Баянхонгор аймгийн ЗДТГ	58.5	71.0	12.5
6	Хөвсгөл аймгийн ЗДТГ	59.4	70.7	11.3
7	Нийслэлийн ЗДТГ	69.3	70.4	1.1
8	Говь-Алтай аймгийн ЗДТГ	56.4	69.6	13.2
9	Дундговь аймгийн ЗДТГ	70.9	67.9	-2.9
10	Завхан аймгийн ЗДТГ	80.4	67.5	-12.8
11	Архангай аймгийн ЗДТГ	76.6	66.8	-9.9
12	Дорноговь аймгийн ЗДТГ	68.1	65.3	-2.8
13	Өмнөговь аймгийн ЗДТГ	61.9	65.3	3.4
14	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	43.8	64.8	21.0
15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	78.2	62.7	-15.5
16	Дархан-Уул аймгийн ЗДТГ	46.5	62.7	16.2
17	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	74.3	61.5	-12.8
18	Хэнтий аймгийн ЗДТГ	67.9	61.4	-6.5
19	Ховд аймгийн ЗДТГ	58.2	60.3	2.1
20	Увс аймгийн ЗДТГ	59.8	55.1	-4.7
21	Төв аймгийн ЗДТГ	86.5	55.1	-31.4
22	Орхон аймгийн ЗДТГ	72.0	49.7	-22.4

³ 2022 оны Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ 43.8-86.5-ийн хооронд байсан байна.

3.2.2. Дүүргүүдийн ЗДТГ-ын гадаад шударга байдлын үнэлгээ

2022 онд нийслэлийн 9 дүүрэг шинээр ГШБҮ-ний судалгаанд хамрагдсан бөгөөд 2023 оны хувьд дүүргүүдийн ГШБҮ нь дунджаар 70.4 оноотой байгаа нь улсын дунджаас 2.4 оноогоор доогуур, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дунджаас 4.1 оноогоор өндөр байна.

Хүснэгт 12. Нийслэлийн ЗДТГ болон дүүргүүдийн ЗДТГ-уудын ГШБҮ, 2022, 2023, оноогоор

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Нийслэл, дүүргүүдийн ГШБҮ		69.3	70.4	1.1
1	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	66.0	84.0	18.0
2	Налайх дүүргийн ЗДТГ	55.7	80.8	25.1
3	Баянзүрх дүүргийн ЗДТГ	59.0	80.7	21.7
4	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	58.7	75.5	16.8
5	Баянгол дүүргийн ЗДТГ	68.6	71.7	3.1
6	Багахангай дүүргийн ЗДТГ	73.0	69.6	-3.4
7	Хан-уул дүүргийн ЗДТГ	75.5	67.9	-7.6
8	Багануур дүүргийн ЗДТГ	66.1	65.1	-1.0
9	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	73.1	56.7	-16.4


Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын хувьд нийслэл, дүүргүүдийн ГШБҮ 84.0 оноотойгоор хамгийн өндөр үнэлэгдсэн бол, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын хувьд 56.7 оноотойгоор хамгийн бага үнэлэгдсэн байна. Сүхбаатар дүүргийн ЗДТГ болон Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-уудын үзүүлэлтүүдийн зөрүүг авч үзвэл Сонгинохайрхан дүүргийн байгууллагын ил тод байдал 21.3-аар, хариуцлагатай байдал 20.4-өөр, авлигын талаарх төсөөлөл 26.4-өөр, авлигын шууд тохиолдол 43.8-аар, авлигын шууд бус тохиолдол 30.3-аар тус тус доогуур байна.

3.2.3. Авлигын эрсдэлийн индекс

Ил тод, хариуцлагатай байдлын индекс нь ГШБҮ тооцоход ашигласан эхний үзүүлэлт бөгөөд 2023 оны үнэлгээ 63.25 гарсан нь 2022 онтой харьцуулахад 0.2 оноогоор буурсан, 2021 онтой харьцуулахад 5.7 оноогоор өссөн байна.

Авлигын эрсдэлийн индексийг тооцохдоо ил тод байдал, хариуцлагатай байдал гэсэн 2 бүлгийн нэгж үзүүлэлтүүдийг ашигласан болно. Ил тод байдлын үнэлгээг 2022 онтой харьцуулахад 1.4-өөр буурсан ба хариуцлагатай байдлын үнэлгээ 1.0-ээр өсжээ. Ил тод байдлын үнэлгээ ийнхүү буурахад төрийн байгууллагуудаар үйлчлүүлэхэд төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл ил тод байсан эсэх асуулгын нийлбэр оноо өмнөх жилээс 4725-аар буурсан нь нөлөөлжээ.

График 9. Авлигын эрсдэлийн индекс, оноор, оноогоор




Төрийн байгууллагуудын ил тод байдлыг авч үзвэл агентлагуудын ил тод байдал хамгийн өндөр буюу 63.6 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ил тод байдал хамгийн бага буюу 51.0 оноогоор үнэлэгджээ. Төрийн байгууллагын үйл ажиллагаа,

хүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал нь аймаг, нийслэлийн ЗДТГ-дын хувьд тааруу байдаг нь харагдаж байна.

Төрийн байгууллагуудын хариуцлагатай байдлыг авч үзвэл агентлагуудын хариуцлагатай байдал хамгийн сайн байсан бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын албан хаагчдын хариуцлагатай байдал мөн л тааруу байдаг нь үр дүнгээс харагдаж байна. Энэ нь төрийн албан хаагчид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүчин чармайлт бага гаргадаг, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал нь аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хэмжээнд их байдгийг харуулж байна.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад ил тод болон хариуцлагатай байдлын үнэлгээ ийнхүү бага гарах болсон шалтгаанд төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл нь ил тод байсан эсэх асуулгын нийлбэр оноо өмнөх оноос 10425-аар, үйлчлүүлэхэд төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл нь ил тод байсан эсэх асуулгын нийлбэр оноо 19625-аар буурсан нь тус тус нөлөөлжээ.

График 10. 2023 оны авлигын эрсдэлийн индекс, байгууллагын төрлөөр, оноогоор



3.2.4. Авлигын индекс

Авлигын индекс нь ГШБҮ-г тооцоход ашигласан сүүлчийн үзүүлэлт бөгөөд 2023 оны үнэлгээгээр 82.4 гарсан нь 2022 онтой харьцуулахад 5.3 оноогоор өссөн дүн юм.


Авлигын индексийг тооцохдоо авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол гэсэн 3 бүлгийн нэгж үзүүлэлтүүдийг ашигласан. Судалгааны үр дүнг 2022 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл 2.9, авлигын шууд тохиолдол 2.9, авлигын шууд бус тохиолдол 10.1-ээр тус тус өсжээ.

Авлигын шууд тохиолдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын 3.3 хувь нь албан хаагчид албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгсөн, 2.9 хувь нь төрийн албан хаагчид шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн, 3.2 хувь нь албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор хандив, бусад санхүүгийн туслалцаа үзүүлсэн хэмээн хариулжээ. Энэхүү үр дүнг 2022 онтой харьцуулахад нэмэлт төлбөр өгсөн тохиолдлын хувь 2.8, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн тохиолдлын тоо 3.4 хувиар, хандив, бусад санхүүгийн туслалцаа үзүүлсэн тохиолдлын тоо 0.6 хувиар тус тус буурчээ.

Мөн судалгаанд оролцогчоос “Танай найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн тухайн байгууллагаас үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэргийг сүүлийн 12 сарын хугацаанд өгч байсныг мэдэх үү? гэсэн асуултад


судалгаанд оролцогчдын 7.1 хувь нь “ тийм” гэж хариулсан ба 72.8 хувь нь “үгүй”, 20 хувь нь “мэдэхгүй/ хариулахаас татгалзсан/” гэж хариулжээ.

График 11. Авлигын индекс, оноор, оноогоор



Авлигын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзэхэд яамдын үнэлгээ агентлаг болон ЗДТГ-уудаас илүү байна. Авлигын шууд болон шууд бус тохиолдол, авлигын талаарх төсөөллийн онооноос харахад аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад харьцангуй бага байгаа нь 2023 оны авлигын индексийн улсын дунджаас 5.3 оноогоор бага байх шалтгаан болжээ. Түүнчлэн авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь 63.3 оноотойгоор, авлигын шууд тохиолдлын үнэлгээнээс 29.1-ээр, шууд бус тохиолдлоос 27.9-өөр доогуур байгаа нь төрийн байгууллагын албан хаагчид төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал, ах дүү танил танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог зэрэгт цаашид ч мөн адил анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.


График 12. Авлигын индекс, байгууллагын төрлөөр, оноогоор



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төрийн албан хаагчдад нэмэлт төлбөр, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн, хандив тусалцаа үзүүлсэн үеийг тодруулахад судалгаанд оролцогчдын 22.6 хувь нь үйлчилгээ авахаас өмнө, 15.9 хувь нь үйлчилгээ авч байхдаа, 18.8 хувь нь үйлчилгээ авсны дараа, 19.1 хувь нь тусгай баяр, тэмдэглэлт өдрөөр өгдөг гэж хариулсан бол, 2.2 хувь нь байнга, 4.2 хувь нь бусад, 1.8 хувь нь тухайн төрийн албан хаагчийг албан тушаалд томилогдоход, 17.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Эдгээр үзүүлэлтийг 2022 оны үзүүлэлттэй харьцуулахад үйлчилгээ авахаас өмнө, үйлчилгээ авсны дараа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг өгдөг гэсэн хариултууд буурсан бол, үйлчилгээ авч байхдаа, тусгай баяр, тэмдэглэлт өдрөөр, байнга нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг


өгдөг гэсэн хариултууд буурчээ. Харин мэдэхгүй /хариулахаас татгалзсан/ хариулт 2023 онд 8.5 хувиар өссөн байна.

График 13. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг яг аль үед өгсөн, өгөх болсон шалтгаан



Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг өгсөн үеийг төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн төрлөөр авч үзвэл үйлчилгээ авахаас өмнө, авсны дараа, тусгай баяр, тэмдэглэлт өдрөөр нэмэлт төлбөр, бэлэг, хандив өгдөг үе нь байгууллагуудын хувьд хувь хүмүүсээс бага байгаа бол хувь хүмүүс, үйлчилгээ авч байхдаа, тухайн төрийн албан хаагчийг албан тушаалд томилогдоход бэлэг өгдөг байдал нь байгууллагаас өндөр байгаа нь дараах графикаас харагдаж байна.


График 14. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг яг аль үед өгсөн бэ?, үйлчлүүлэгчдийн төрлөөр



Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төрийн албан хаагчдад нэмэлт төлбөр, бэлэг, хандив үзүүлсэн шалтгааныг асуухад 30.2 хувь нь ажлаа хурдан бүтээхийн тулд, 22.8 хувь


нь талархлаа илэрхийлж, 7.3 хувь нь давуу байдал олж авахын тулд, 9.1 хувь нь тухайн төрийн албан хаагчийн хүсэлтээр, 7.7 хувь нь хэвшмэл болсон, 3.1 хувь нь бусад, 0.5 хувь нь хариуцлагаас зайлсхийхийн тулд, 19.3 хувь нь хариулахаас татгалзсан байна. Иргэд, байгууллагын төлөөллийн хувьд яагаад ажлаа бүтээхийн тулд өгдөг талаар тодруулахад төрийн үйлчилгээ удаан цаг хугацаа их шаарддаг учраас төрийн үйлчилгээг хурдан авах зорилгоор өгдөг гэж хариулж байв. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив зэргийг өгөх болсон шалтгааныг 2022 оны үзүүлэлттэй харьцуулахад ажлаа хурдан бүтээхийн тулд өгдөг хүмүүсийн тоо 6.2, талархлаа илэрхийлж өгдөг хүмүүсийн тоо 2.9, төрийн албан хаагчийн хүсэлтээр өгдөг хүмүүсийн тоо 0.3, хариуцлагаас зайлсхийхийн тулд өгсөн хүмүүсийн тоо 2.1, давуу байдал олж авахын тулд өгсөн хүмүүсийн тоо 3.2 хувиар тус тус буурчээ. Харин бусад болон хэвшмэл болсон, хариулахаас татгалзсан хүмүүсийн тоо өмнөх жилээс өссөн байна.

График 15. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив зэргийг өгөх болсон шалтгаан юу бэ?



Төрийн байгууллагаар үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив зэргийг өгөх шалтгааныг үйлчлүүлэгчдийн төрлөөр авч үзвэл байгууллага, хувь хүмүүсийн хувьд аль аль нь ажлаа хурдан бүтээх, талархлаа илэрхийлэх гэж өгдөг байдал нь ойролцоо байгаа бол, хувь хүмүүсийн хувьд байгууллагуудаас илүү давуу байдал олж авахын тулд өгдөг болох нь графикаас харагдаж байна.

График 16. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцаа үзүүлэх болсон шалтгаан юу бэ?, үйлчлүүлэгчдийн төрлөөр




3.3 Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн

Энэхүү бүлэгт **дотоод шударга байдлын үнэлгээний үр дүнг** орууллаа.

3.3.1. ДШБҮ-ний ерөнхий дүн

Төрийн байгууллагуудын үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын төлөөллөөс ДШБҮ-ний судалгааг авсан. Энэхүү үнэлгээг соёлын индекс, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс гэсэн 2 дэд үзүүлэлтийн дунджаар тооцсон болно. Уг 2 дэд үзүүлэлтийн дунжийг тооцоход 7 бүлгийн 26 нэгж үзүүлэлтийг ашигласан. 2023 онд төрийн байгууллагуудын ДШБҮ 83.4 болж өмнөх онтой харьцуулахад 1.2 оноогоор нэмэгдсэн бөгөөд энэ нь 2018 оноос хойш тасралтгүй өсөж буй үр дүн юм. ДШБҮ-г төрийн байгууллагын төрлөөр ангилан авч үзвэл яамдын үнэлгээ өмнөх онтой харьцуулахад 1.0 оноогоор өссөн, агентлагуудын үнэлгээ 1.4 оноогоор өссөн, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ 0.9 оноогоор өссөн байлаа. Агентлагуудын ДШБҮ нь хамгийн их өсөлт үзүүлэхэд Ойн газар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар гэх мэт өндөр ДШБҮ-тэй газрууд шинээр орж ирсэн нь нөлөөлснөөс гадна дунджаас доогуур үнэлгээтэй байсан Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой юм.

График 17. ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр



ДШБҮ-ний үр дүнг байгууллагаар ангилан харвал хамгийн өндөр үнэлгээг “Жижиг дунд үйлдвэрийн газар” авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 0.49 оноогоор өссөн байв. Үүнд хамгийн их нөлөөлж байгаа зүйл нь удирдлагын хүсэл эрмэлзэл бөгөөд өмнө оноос 4.0 оноогоор өсөж 89.5 болсон байна. Хамгийн өндөр үнэлгээтэй 5 байгууллагаас “Эдийн засгийн хөгжлийн яам” өмнөх онтой харьцуулахад хамгийн их оноогоор буюу 5.81 оноогоор өссөн нь онцлох үр дүн байсан. Харин ДШБҮ-ээр хамгийн бага үнэлгээг “Биеийн тамир, спортын улсын хороо” авсан бөгөөд өмнөх оноос 0.81 оноогоор буурсан байлаа. Дэд үзүүлэлтээр нь аваад үзвэл авлигын эсрэг тогтолцоо дээр 51.5 оноо, төсвийн зарцуулалт дээр 52.6 оноо авсан нь хамгийн их нөлөө үзүүлжээ. Эдийн засгийн хөгжлийн яам нь өнгөрсөн жил хорин наймд эрэмбэлэгдэж байсан бол энэ жил хоёрдугаар байранд эрэмбэлэгдсэн байна. Үүний гол шалтгаан нь удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл бөгөөд өмнө жилийхээс 15.6 оноогоор өссөн байна.

Хүснэгт 13. ДШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2022 оны эрэмбэ	2023 оны эрэмбэ	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	2	1	92.7	93.2	0.49
2	Эдийн засаг, хөгжлийн яам	28	2	84.1	89.9	5.81
3	Орхон аймгийн ЗДТГ	11	3	86.9	89.9	2.95
4	Батлан хамгаалах яам	4	4	91.0	89.5	-1.41
5	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	8	5	87.8	89.5	1.66
Хамгийн бага үнэлгээтэй:						
67	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	59	67	77.2	75.1	-2.06
68	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	25	68	84.5	74.8	-9.71
69	Мал эмнэлгийн ерөнхий газар	67	69	69.6	74.6	5.05
70	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	65	70	73.4	73.7	0.26
71	Биеийн тамир, спортын улсын хороо	66	71	69.9	69.1	-0.81

Энэ удаагийн судалгаанд 16 яам хамрагдсан бөгөөд ДШБҮ 1.0 оноогоор өсөж 83.9 болжээ. Яамдаас хамгийн өндөр үнэлгээг “Эдийн засаг хөгжлийн яам” 89.9 оноогоор авсан бөгөөд өмнөх оноос 5.8 оноогоор нэмэгдсэн байв. Энэхүү өсөлтөд авлигын эсрэг тогтолцоо гол нөлөө үзүүлсэн бөгөөд өмнөх оноос 10.2 оноогоор нэмэгдэж 79.8 болсон байна. Удаах байранд “Батлан хамгаалах яам” 89.5 оноогоор оржээ. Батлан хамгаалах яам нь ШБҮ-ний 2022 оны судалгаанд ДШБҮ-ээр хамгийн өндөр үнэлгээг авч байсан ба энэ удаа өмнөх жилийн амжилтаа бататгаж, 2-р байранд эрэмбэлэгдсэн байна. Яамдаас хамгийн бага үнэлгээг “Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам” 74.8 оноогоор авсан бөгөөд өмнөх үнэлгээтэй харьцуулахад 9.7 оноогоор буурсан байна. Буурсан шалтгааныг тодруулахад үүрэг даалгаврын шударга байдал өмнөх оноос 19.4 оноогоор буурч 66.2 болсон нь гол нөлөө үзүүлсэн байна. Судалгаанд хамрагдсан 16 яамны 5 нь өмнөх онтой харьцуулахад үнэлгээ буурсан, харин 11 нь үнэлгээгээ сайжруулж чаджээ. ДШБҮ-г тодорхойлсон 2022 оны судалгаанд 16 яам хамрагдсан бөгөөд мөн адил 11 нь өмнөх үнэлгээгээ сайжруулсан байжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдсан яамдын 9 нь ДШБҮ-ний 2023 оны дундаж үнэлгээнээс дээгүүр түвшинд үнэлэгдсэн байна.

Хүснэгт 14. Яамдын ДШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Яамдын ДШБҮ		82.9	83.9	1.0
1	Эдийн засаг, хөгжлийн яам	84.1	89.9	5.8
2	Батлан хамгаалах яам	91	89.5	-1.4
3	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	79.2	88.6	9.4
4	Сангийн яам	88.5	85.1	-3.5
5	Гадаад харилцааны яам	84.2	85	0.8
6	Соёлын яам	84.5	84.6	0.1
7	Эрчим хүчний яам	84	84.6	0.5
8	Барилга, хот байгуулалтын яам	85.7	84.2	-1.5
9	Хууль зүй, дотоод хэргийн яам	83.4	84	0.5
10	Боловсрол, шинжлэх ухааны яам	80.5	83.4	2.9
11	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	77	83.1	6.1
12	Зам, тээврийн хөгжлийн яам	78.4	82.9	4.5
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	85.8	82.7	-3.2
14	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	80.3	80.7	0.4
15	Эрүүл мэндийн яам	75.5	79.9	4.4
16	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	84.5	74.8	-9.7

Судалгаанд төрийн захиргааны байгууллага болох 33 агентлаг хамрагдсан бөгөөд агентлагуудын ДШБҮ 82.9 оноогоор үнэлэгдэж өмнөх онтой харьцуулахад 1.1 оноогоор өссөн байна. ДШБҮ-ний 2022 оны судалгаагаар 14 агентлаг өмнөх үнэлгээгээ сайжруулж байсан бол энэ удаа 17 нь өмнөх үнэлгээгээ сайжруулж 1 агентлаг өмнөх онтойгоо тэнцүү оноогоор үнэлэгдсэн байна. Түүнчлэн агентлагуудаас 21 нь ДШБҮ-ний 2023 оны дундаж үнэлгээнээс дээгүүр түвшинд үнэлэгдсэн байна.

Судалгаанд хамрагдсан агентлагуудаас “Жижиг дунд үйлдвэрийн газар” хамгийн өндөр буюу 93.2 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 0.5 оноогоор өсжээ. Ихэнх дэд үзүүлэлтүүд нь өмнөх оноос төдийлөн өсөөгүй бөгөөд хамгийн өсөлттэй гарсан үзүүлэлт нь албан бус хэм хэмжээ буюу 6.7 оноогоор өсөж 96.3 болсон байна.

Үүний дараа “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” 89.5 оноогоор үнэлэгдэж удаах байрыг эзэлсэн байна. Түүнчлэн өмнөх оны үнэлгээний дүнгээс хамгийн их оноогоор сайжирсан агентлаг бол “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар” юм. Тус байгууллагын ДШБҮ 2022 онд 79.6 оноогоор үнэлэгдэж байсан бол энэ удаа 11-р байранд 86 оноотойгоор эрэмбэлэгдэж байгаа нь сайшаалтай үр дүн билээ. Энэхүү өсөлтөд бүх дэд үзүүлэлтүүд өссөн нь нөлөөлснөөс гадна албан бус хэм хэмжээ өмнөх оноос 13.4 оноогоор өсөж 85.7 болсон нь гол нөлөө үзүүлсэн байна. Мөн энэ жилээс “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар”, “Ойн газар”, “Шүүхийн шинжилгээний ерөнхий газар” гэх 3 газар шинээр нэмэгдсэн бөгөөд эдгээр газрууд нь бүгд 2023 оны ДШБҮ-с өндөр оноотой байгаа юм. Хамгийн бага оноог “Биеийн тамир, спортын улсын хороо” авсан бөгөөд өмнөх оноос 0.81 оноогоор буурсан байлаа. Дэд үзүүлэлтээр нь аваад үзвэл авлигын эсрэг тогтолцоо дээр 51.5 оноо, төсвийн зарцуулалт дээр 52.6 оноо авсан нь хамгийн их нөлөө үзүүлжээ. Мөн бусад дэд үзүүлэлтүүд нь өмнөх оноос бага хэмжээгээр буурсан байна. Харин өмнөх оноос хамгийн их оноогоор буурсан байгууллага бол Иргэний нисэхийн ерөнхий газар юм. Бүх дэд үзүүлэлт нь өмнөх оноос буурснаас гадна удирдлагын хүсэл эрмэлзэл хамгийн их буюу 9.9 оноогоор буурч 64.7 болсон байна.

Хүснэгт 15. Агентлагуудын ДШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Агентлагуудын ДШБҮ		81.8	82.9	1.07
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	92.7	93.2	0.5
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	87.8	89.5	1.7
3	Онцгой байдлын ерөнхий газар	86.3	88.9	2.6
4	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	93.9	88.8	-5.1
5	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-	88.2	-
6	Гадаадын иргэн, харьяатын газар	84.4	87.9	3.5
7	Стандарт, хэмжил зүйн газар	85.5	87.1	1.6
8	Боловсролын ерөнхий газар	86.9	86.9	0
9	Ойн газар	-	86.9	-
10	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	80.8	86.8	6
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	79.6	86	6.4
12	Архивын ерөнхий газар	82	85.9	3.9
13	Улсын бүртгэлийн ерөнхий газар	80.7	85.2	4.4
14	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	79.5	85	5.6
15	Усны газар	81.4	84.5	3.1
16	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	83.2	84.1	0.9
17	Татварын ерөнхий газар	79.2	83.9	4.7
18	Төрийн худалдан авах ажиллагааны газар	85.8	83.9	-2
19	Цаг уур, орчны шинжилгээний газар	79.7	83.8	4.1
20	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар	-	83.3	-

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
21	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	84	82.9	-1.1
22	Нийгмийн даатгалын ерөнхий газар	86.4	82.8	-3.6
23	Цагдаагийн ерөнхий газар	78	82.5	4.5
24	Оюуны өмчийн газар	84.6	82.2	-2.3
25	Үндэсний геологийн алба	79.4	82	2.6
26	Соёл, урлагийн газар	84.9	80.4	-4.4
27	Ашигт малтмал, газрын тосны газар	79.2	76.9	-2.3
28	Иргэний нисэхийн ерөнхий газар	82	76.8	-5.2
29	Гаалийн ерөнхий газар	77.1	76.7	-0.3
30	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	77.2	75.1	-2.1
31	Мал эмнэлгийн ерөнхий газар	69.6	74.6	5.1
32	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	73.4	73.7	0.3
33	Биеийн тамир, спортын улсын хороо	69.9	69.1	-0.8

Судалгаанд 21 аймаг болон нийслэлийн ЗДТГ хамрагдсан бөгөөд эдгээрийн ДШБҮ нь 83.3 болж өмнөх оноос 0.9 оноогоор өсжээ. 2022 оны ДШБҮ-ний үр дүнгээс үзэхэд ЗДТГ-уудаас 14 нь дотоод үйл ажиллагаагаа сайжруулан ажилласны үр дүнд үнэлгээгээ сайжруулж байсан бол энэ удаа 12 нь үнэлгээгээ нэмэгдүүлжээ.

Өмнөх судалгаатай харьцуулахад ЗДТГ-аас нэгдүгээрт эрэмбэлэгдэж байсан Говьсүмбэр аймгийн ЗДТГ энэ удаа хоёрдугаарт эрэмбэлэгдсэн бол хоёрдугаарт эрэмбэлэгдэж байсан Төв аймгийн ЗДТГ аравдугаарт тус тус оржээ.

Мөн энэ удаагийн судалгааны үр дүнгээр Баян-Өлгий аймгийн ЗДТГ болон Сүхбаатар аймгийн ЗДТГ-ууд үнэлгээгээ хамгийн их оноогоор өссөн байна. Баян-өлгий аймгийн өсөлтөд үүрэг даалгаврын шударга байдал хамгийн их нөлөөлсөн бөгөөд өмнөх оноос 15 оноогоор өсөж 85.4 болсон байна. Төв аймаг өмнөх оноос хамгийн их буюу 6.01 оноогоор буурсан байна. Үүнийг тодруулахад авлигын эсрэг тогтолцоо 10.7 оноогоор буурч 67.1 болсон байна. Харин энэ жил хамгийн бага оноо авсан Завхан аймгийн хувьд төсвийн зарцуулалт өмнөх оноос хамгийн их оноогоор буурсан бөгөөд 10.7 оноогоор буурч 84.0 оноо болсон байна.

Хүснэгт 16. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ, 2022, 2023 оныг харьцуулсан үнэлгээ


№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ	82.4	83.3	0.88
1	Орхон аймгийн ЗДТГ	86.9	89.9	2.95
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	92.4	88.4	-3.93
3	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	86.3	87.6	1.33
4	Дорнод аймгийн ЗДТГ	83.5	87.4	3.87
5	Дундговь аймгийн ЗДТГ	87.7	86.7	-1
6	Булган аймгийн ЗДТГ	81.9	86.4	4.47
7	Өмнөговь аймгийн ЗДТГ	76.7	86.1	9.41
8	Архангай аймгийн ЗДТГ	80.1	85	4.83
9	Нийслэлийн ЗДТГ	85	84.2	-0.82
10	Төв аймгийн ЗДТГ	89.6	83.6	-6.01
11	Увс аймгийн ЗДТГ	86.6	83.4	-3.16
12	Ховд аймгийн ЗДТГ	81.3	83.1	1.83
13	Хэнтий аймгийн ЗДТГ	83	83.1	0.14
14	Сүхбаатар аймгийн ЗДТГ	75.3	83	7.61
15	Өвөрхангай аймгийн ЗДТГ	87.7	82.4	-5.25
16	Баянхонгор аймгийн ЗДТГ	82.9	81.3	-1.68
17	Хөвсгөл аймгийн ЗДТГ	77.3	81.2	3.96
18	Дорноговь аймгийн ЗДТГ	87.9	80.4	-7.5
19	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	69.4	78.6	9.19
20	Дархан-Уул аймгийн ЗДТГ	82.6	78.5	-4.11

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
21	Говь-Алтай аймгийн ЗДТГ	68.6	76.3	7.76
22	Завхан аймгийн ЗДТГ	80.2	75.7	-4.43

3.3.2. Соёлын индекс


ДШБҮ-г тооцоход ашигласан эхний үзүүлэлт бол соёлын индекс юм. Соёлын индексийг тооцохдоо албан бус хэм хэмжээ болон авлигын эсрэг тогтолцоо гэсэн хоёр дэд үзүүлэлтийг ашигласан. Судалгааны үр дүнгээс үзэхэд соёлын индекс 76.2 болж өмнөх оноос 1.2 оноогоор нэмэгджээ. Гэсэн хэдий ч тус үнэлгээ нь ДШБҮ-ний дунджаас 6.0 оноогоор бага байна. Хэдийгээр албан бус хэм хэмжээ болон авлигын эсрэг тогтолцоотой холбоотой үзүүлэлтүүд нэмэгдсэн байгаа ч төрийн байгууллагын албан хаагчдын дунд албан үүргээ ил тодоор гүйцэтгэдэггүй, хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг, бусдын нөлөөнд автдаг, төрийн байгууллагуудын дунд авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэн бүрэлдээгүй байдаг гэх зэрэг асуудлууд байсаар байгааг илэрхийлж байв. Соёлын индекс бага байгаа гол шалтгаан нь агентлагуудын соёлын индекс бөгөөд өмнөх оноос 1.4 оноогоор буурсан байна. Яамдын соёлын индекс өмнөх оноос 0.9 оноогоор, ЗДТГ-ын соёлын индекс 1.1 оноогоор тус тус өссөн байна.

График 18. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Соёлын индексийг байгууллагуудын төрлөөр нь авч үзвэл аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын эсрэг тогтолцоо 82.7 оноогоор үнэлэгдсэн байгаа нь яамдын болон агентлагуудын үнэлгээтэй харьцуулахад маш их байна. Өөрөөр хэлбэл яамдын болон агентлагуудын албан хаагчидтай харьцуулахад ЗДТГ-ын албан хаагчдын дунд албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэггүй, танил талынхаа нөлөөнд автаж, ашиг сонирхлоо дээгүүр тавих, бусдад дарамт, шахалт үзүүлэх, нөлөөлөх байдал харьцангуй бага байдаг гэсэн үг юм. Иймд яамд болон агентлагуудад энэ чиглэлээр дотоод үйл ажиллагаа, сургалт, хөтөлбөр аяныг зохион байгуулах нь үр дүнтэй.

График 19. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр




3.3.3. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

ДШБҮ-г тооцоход ашигласан сүүлийн үзүүлэлт нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс юм. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хүний нөөц, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, удирдлагын хүсэл, эрмэлзэл зэрэг 5 бүлгийн нэгж үзүүлэлтүүдээс хамаарч байна. Уг индексийг 2022 онтой харьцуулахад 1.1 оноогоор нэмэгджээ.


Индексийг хэмжихэд ашигласан 5 бүлгээс хамгийн тааруу үнэлэгддэг бүлэг нь удирдлагын хүсэл эрмэлзэл бөгөөд 2022 онтой харьцуулахад 0.2 оноогоор буурсан байв. Энэхүү үзүүлэлтээс бусад бүх үзүүлэлт нь өмнөх оноос өссөн бөгөөд үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг бага хэмжээгээр өсөхөд нөлөөлжээ. Яамдын хувьд энэхүү индекс нь өмнөх оноос 1.0 оноогоор өссөн бол агентлагын индекс 0.4 оноогоор, ЗДТГ-ын индекс нь 0.7 оноогоор тус тус өссөн байна.

График 20. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзэхэд өмнөх оны үр дүнтэй төдийлөн ялгаа харагдахгүй байгаа боловч үүрэг даалгаврын шударга байдал, удирдлагын хүсэл, эрмэлзлийн үнэлгээ агентлагуудын хувьд ялимгүй бага байна. Дэд үзүүлэлтээс хамгийн их өссөн үзүүлэлт нь Яамдын төсвийн зарцуулалт бөгөөд өмнөх оноос 3.3 оноогоор өсөж 94.6 болсон байна.

График 21. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр



Төрийн албан хаагчдаас сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 3 хувь нь

“тийм” гэж хариулсан нь 2022 онтой харьцуулахад 0.2 пунктээр нэмэгджээ. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгааныг тодруулахад 33.7 хувь нь удирдах албан тушаалтны шийдвэрээр, 24.0 хувь нь хяналт сул байдаг, 18.1 хувь нь уламжлал болсон учраас, 7.7 хувь нь ёс зүй хариуцлагатай байдал дутсанаас, 9.6 хувь нь бусад хэмээн тус тус хариулжээ.

График 22. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан



Хэдийгээр удирдлагын шийдвэрээр гэж хариулсан албан хаагчдын хувь 2022 онтой харьцуулахад 5.5 пунктээр буурсан боловч төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай байдаг нь хэвээр хадгалагдсаар л байна.


Мөн 2022 онтой харьцуулахад хяналт сул байдгаас шалтгаалан төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон гэж хариулсан хариултын хувь 3.0 пунктээр буурсан нь холбогдох хууль, хяналтын байгууллагын төлөөллүүд энэ асуудалд анхаарал хандуулж ажилласныг илэрхийлж байна. Судалгаанд оролцогчдын хувьд байгууллагын авлигыг хянах дотоод механизм сул буюу илрүүлэх, хянах чиглэлд анхаарал бага хандуулдаг, энэ чиглэлд төлөвлөгөөт ажил бага хийдэг, авлига авсан хүнд тооцох хариуцлага ил тод биш байдаг, удирдлагын түвшинд ажилладаг хүмүүсийн авлигыг хянах, илрүүлэх хүсэл, эрмэлзэл бага байдаг зэрэг шалтгаан нь ийнхүү хариулахад нөлөөлжээ.

Харин уламжлал болсон учраас гэж хариулсан хариултын хувь 7.5 пунктээр нэмэгдсэн нь тэрхүү хэвшмэл сэтгэлгээг арилгах хүрээнд хийгдсэн ажлууд үр дүнгүй байсан нь харагдаж байна.

3.3.4 Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ


Энэ удаагийн судалгааны ажилд өмнө жилийн адил дүүргүүдийн ЗДТГ-ыг судалгаанд хамруулсан. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ-ний дундаж 84.5 байгаа нь ДШБҮ-ний дундажтай харьцуулахад 1.1 оноогоор илүү үр дүн юм. Дүүргүүдээс Баянгол дүүргийн ЗДТГ болон Налайх дүүргийн ЗДТГ хамгийн өндөр үнэлгээг авсан бол Багахангай болон Хан-Уул дүүргийн ЗДТГ-ууд хамгийн бага үнэлгээг авчээ. Дүүргүүдийн хувьд таван дүүрэг ДШБҮ-ний дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна. Хан-Уул дүүрэг хамгийн сүүлд ороход төсвийн зарцуулалт хамгийн их нөлөөлсөн бөгөөд өмнө оноос 22 оноогоор буурсан байна.

График 23. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ




Дүүргүүдийн ДШБҮ-г соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн хувьд харьцуулан дараах графикт харуулав. Графикаас харахад соёлын индекс 76.2, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 90.6 оноогоор үнэлэгдэж, хоёр индексийн хувьд ихээхэн зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл дүүргийн ЗДТГ-уудад хүний нөөц, төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, удирдлагын хүсэл эрмэлзлээс илүү албан хаагчдын албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэггүй, танил талынхаа нөлөөнд автаж, ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг, бусдад дарамт, шахалт үзүүлэх, нөлөөлөх байдал түлхүү байдгийг илэрхийлж байна.

График 24. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд



Соёлын индексийг дүүргүүдээр задлан үзэхэд Багахангай, Баянгол, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ууд бусад дүүргээс бага оноогоор үнэлэгдсэн байна. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн хувьд төдийлөн их ялгаа харагдахгүй бөгөөд ганцхан Хан-Уул дүүрэг 90 хүрэхгүй оноо авсан байна.

График 25. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд үзүүлэлтээр, дүүрэг тус бүрээр



Дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын индекс бага оноогоор үнэлэгдсэн шалтгаан нь авлигын эсрэг тогтолцоо 70.5 оноогоор үнэлэгдсэнтэй шууд холбоотой байв. Тодруулбал өмнө жилийн адилаар дүүргүүдийн ЗДТГ-уудад авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалсан тогтолцоо бүрэн нэвтрээгүй, авлигын зөрчил гаргасан албан хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэх тогтолцоо хангалттай бүрдээгүй, авлигыг хянах дотоод механизм сул байгаа гэсэн үг юм. Дундаж үнэлгээнээс дээгүүр оноотой гурван дүүрэг байгаа бөгөөд үүнээс ганцхан Баянгол дүүрэг 80-с дээш оноо авсан байна.

Хүснэгт 17. Дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын индекс, дэд үзүүлэлтээр

№	Байгууллагын нэр	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Баянгол дүүргийн ЗДТГ	88.2	82.8	85.5
2	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	88.8	70.7	79.7
3	Налайх дүүргийн ЗДТГ	89.9	69.3	79.6
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	86.2	70.7	78.5
5	Багануур дүүргийн ЗДТГ	82.8	71.7	77.3
6	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	80.4	69.5	75.0
7	Хан-уул дүүргийн ЗДТГ	81.4	67.7	74.6
8	Багахангай дүүргийн ЗДТГ	80.3	66.9	73.6
9	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	80.0	64.8	72.4
Дундаж үнэлгээ		84.2	70.5	77.3

Дүүргүүдийн үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн нэгж үзүүлэлтүүдээс удирдлагын хүсэл эрмэлзэл 72.6 буюу хамгийн бага оноогоор үнэлэгджээ. Уг нэгж үзүүлэлтийг дүүргээр задлан харахад Багахангай дүүргийн ЗДТГ хамгийн бага буюу 70.2 оноо авсан байна.

Хүснэгт 18. Дүүргүүдийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс


№	Байгууллагын нэр	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Багануур дүүргийн ЗДТГ	98.5	98.1	92.7	100.0	70.8	92.0
2	Багахангай дүүргийн ЗДТГ	99.6	92.7	89.2	100.0	70.2	90.3
3	Баянгол дүүргийн ЗДТГ	99.6	99.3	91.1	100.0	77.1	93.4
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	99.8	98.9	95.8	100.0	68.6	92.6
5	Налайх дүүргийн ЗДТГ	99.3	96.7	93.0	100.0	79.9	93.8
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	98.5	96.6	90.8	100.0	72.1	91.6
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	99.8	99.4	97.4	100.0	71.3	93.6
8	Хан-уул дүүргийн ЗДТГ	99.6	76.4	85.9	96.7	72.4	86.2
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	98.7	98.1	87.1	100.0	70.8	90.9
Дундаж үнэлгээ		99.3	95.1	91.4	99.6	72.6	91.6

3.4. БОУ-ний ерөнхий дүн

Төрийн байгууллагуудын БОУ-д тухайн байгууллагын харьяа дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, аудитор, хяналтын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг хамруулсан. Энэхүү үнэлгээг авлигын талаарх төсөөлөл, авлигын хяналт, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүдийн дунджаар тооцсон болно.

БОУ-ний 2023 оны дүн 73.7 болж 2022 онтой харьцуулахад 4.7 оноогоор нэмэгдсэн нь шударга байдлын үнэлгээ хийгдэж эхэлсэн 2015 оноос хойших хамгийн өндөр өсөлт байлаа. Үнэлгээний өсөлтийг байгууллагын төрлөөр нь харьцуулбал, яамдын БОУ-ний дүн хамгийн өндөр 10.2 оноогоор нэмэгдсэн байна. 2023 оны хамгийн бага өсөлттэй (2.9) нь Агентлагуудын БОУ байна. Аймаг нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний дүнг өмнө онтой харьцуулахад 3.4 оноогоор нэмэгджээ. БОУ-ний өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн буюу хамгийн өндөр оноогоор өссөн үзүүлэлт нь авлигыг хянах механизм байна. Тус үзүүлэлт нь 2022 ны үнэлгээнээс 8.5 оноогоор (яамд-12.8, агентлаг-9.1, аймаг, нийслэлийн ЗДТГ-4.0) нэмэгдсэн.

График 26. БОУ, оноогоор, байгууллагын төрлөөр



БОУ-ээр “Гадаадын иргэн, харьяатын газар” нэгдүгээрт, “Стандарт хэмжил зүйн газар” хоёрдугаарт, “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” гуравдугаарт, “Боловсролын

ерөнхий газар” дөрөвдүгээрт, “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар” тавдугаарт эрэмбэлэгджээ. Эдгээр байгууллагуудаас “Стандарт хэмжил зүйн газар” -ын үнэлгээ өмнө оноос хамгийн олон оноогоор (17.4) нэмэгджээ. Нэгдүгээрт эрэмбэлэгдсэн “Гадаадын иргэн, харьяатын газар”-ын удирдлагын авлигатай тэмцэн хүсэл хамгийн олон оноогоор нэмэгдсэн бөгөөд үүнийг илэрхийлэх асуултуудаас “Дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл” хамгийн сайн өсөлтийг үзүүлжээ.

Хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллагаас 3 байгууллагын оноо өмнө оноос дунджаар 17.4 оноогоор буурчээ. “Нийгмийн даатгалын ерөнхий газар”-ын үнэлгээ 25.3-аар буурч хамгийн бага 56.5 оноогоор үнэлэгджээ.

2022 оны үнэлгээгээр хамгийн өндөр оноотой 5 байгууллага энэ удаад өндөр үнэлгээтэй 5 байгууллагын жагсаалтад багтаагүй. Хамгийн өндөр үнэлгээ авсан 5 байгууллага бүгд агентлаг бол хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудын ихэнх нь аймгийн ЗДТГ байна.

Хүснэгт 19. БОУ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2022 оны эрэмбэ	2023 оны эрэмбэ	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Гадаадын иргэн, харьяатын газар	25	1	71.7	86.9	15.1
2	Стандарт, хэмжил зүйн газар	42	2	68.0	85.4	17.4
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	5	3	81.2	85.2	4.0
4	Боловсролын ерөнхий газар	24	4	71.8	85.1	13.4
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	9	5	78.0	83.3	5.3
Хамгийн бага үнэлгээтэй:						
67	Увс аймгийн ЗДТГ	17	67	75.7	59.9	-15.79
68	Ховд аймгийн ЗДТГ	65	68	54.2	59.0	4.84
69	Иргэний нисэхийн ерөнхий газар	37	69	68.7	57.7	-10.99
70	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	69	70	45.3	56.8	11.53
71	Нийгмийн даатгалын ерөнхий газар	3	71	81.8	56.5	-25.30

Яамдын БОУ-ний дундаж 77.3 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 10.2 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт юм. 2015-2022 оны дүнгээс харахад яамдын БОУ 2019 онд 4.5 оноогоор нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлт байсан бол энэ жилийн хувьд дээд өсөлтийг үзүүлжээ. Хамгийн өндөр үнэлгээг “Цахим хөгжил, харилцаа холбооны яам” авч нэгдүгээрт “Гадаад харилцааны яам” хоёрдугаарт, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гуравдугаарт, “Эрүүл мэндийн яам” дөрөвдүгээрт, “Эдийн засаг хөгжлийн яам” тавдугаарт эрэмбэлэгджээ. Эхний 3-т эрэмбэлэгдсэн яамны авлигыг хянах механизмын оноо хамгийн их (дунджаар 24.5 оноо) нэмэгдсэн. 2022 оны үнэлгээнээс оноо нь буурсан 3 яам байгаа бол “Эрүүл мэндийн яам”-ны оноо нь хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн юм. “Эрүүл мэндийн яам”-ны хувьд авлигын талаарх төсөөллийн оноо хамгийн их өссөн бөгөөд тус үзүүлэлтийг илэрхийлэх асуултуудаас “Албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийх ёсгүй үйлдлийг хийдэг эсэх” гэсэн асуултын оноо хамгийн их нэмэгджээ.

Яамдаас хамгийн бага үнэлгээг “Соёлын яам”, “Зам, тээврийн хөгжлийн яам”, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” авчээ. Сүүлд эрэмбэлэгдсэн 3 яамнаас “Соёлын яам”, “Зам, тээврийн хөгжлийн яам”-ны оноо буурч, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-ны үнэлгээ нэмэгджээ. “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” болон “Соёлын яам”-ны авлигын талаарх

төсөөллийн оноо хамгийн ихээр (Соёлын яам, -18.7, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, -13.2) буурсан бол “Зам, тээвэр хөгжлийн яам”-ны авлигыг хянах механизм (-10.4), авлигын талаарх төсөөлөл (-10.1) -ийн оноо ойролцоо дүнгээр буурчээ.

Хүснэгт 20. Яамдын БОУ, 2022, 2023 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Яамдын БОУ		67.1	77.3	10.2
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	66.8	83.2	16.4
2	Гадаад харилцааны яам	69.5	82.9	13.4
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	68.6	82.4	13.8
4	Эрүүл мэндийн яам	56.6	80.7	24.1
5	Эдийн засаг, хөгжлийн яам	81.3	79.8	-1.5
6	Хууль зүй, дотоод хэргийн яам	57.7	79.7	22.0
7	Эрчим хүчний яам	77.4	79.2	1.8
8	Барилга, хот байгуулалтын яам	64.6	78.4	13.8
9	Батлан хамгаалах яам	73.0	77.9	4.9
10	Боловсрол, шинжлэх ухааны яам	60.3	77.6	17.3
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	67.6	75.7	8.1
12	Сангийн яам	60.5	75.1	14.6
13	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	49.5	71.8	22.3
14	Соёлын яам	76.0	71.6	-4.4
15	Зам, тээврийн хөгжлийн яам	77.0	71.3	-5.7
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	67.6	69.1	1.5

Агентлагуудын БОУ-ний дундаж 75.3 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 2.9 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт юм. Хамгийн өндөр үнэлгээг “Гадаадын иргэн, харьяатын газар” авч нэгдүгээрт эрэмбэлэгдсэн бол хоёрдугаарт “Стандарт, хэмжил зүйн газар”, гуравдугаарт “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” дөрөвдүгээрт “Боловсролын ерөнхий газар”, тавдугаарт “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар” эрэмбэлэгджээ. Эдгээр агентлагуудаас “Стандарт, хэмжил зүйн газар”, “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар”, “Боловсролын ерөнхий газар”-ын авлигыг хянах механизм, “Гадаадын иргэн, харьяатын газар”, “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар”-ын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл хамгийн их оноогоор нэмэгджээ.

Агентлагуудаас “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үнэлгээ өмнө оноос хамгийн олон оноогоор өссөн бөгөөд дэд үзүүлэлтүүдээс авлигыг хянах механизм (30.7), авлигын талаарх төсөөлөл (20.8) хамгийн их сайжирчээ.

2023 оны үнэлгээнд 3 агентлаг шинээр нэмэгдэж, нэг агентлаг хасагдсан бөгөөд гурван агентлаг тутмын нэг буюу 11 агентлагийн оноо 2022 оны үнэлгээнээс буурсан (дунджаар 8.3 оноогоор буурсан) байна.

Агентлагуудаас хамгийн бага үнэлгээг “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”, “Иргэний нисэхийн ерөнхий газар”, “Нийгмийн даатгалын ерөнхий газар” авчээ. Эдгээр гурван байгууллагын БОУ дунджаар 15.3 оноогоор багассан бөгөөд задлан харвал авлигын талаарх төсөөлөл хамгийн олон оноогоор (дунджаар -32.5) буурчээ.

Хүснэгт 21. Агентлагуудын БОУ, 2022, 2023 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Агентлагуудын БОУ		72.4	75.3	2.9
1	Гадаадын иргэн, харьяатын газар	71.7	86.9	15.2
2	Стандарт, хэмжил зүйн газар	68	85.4	17.4
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	81.2	85.2	4.0
4	Боловсролын ерөнхий газар	71.8	85.1	13.3

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
Агентлагуудын БОУ		72.4	75.3	2.9
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	78	83.3	5.3
6	Төрийн худалдан авах ажиллагааны газар	73.1	83.1	10.0
7	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	80.7	82.5	1.8
8	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	62.6	81.5	18.9
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	69.5	81.4	11.9
10	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	77.3	80.7	3.4
11	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-	80.3	-
12	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	65.9	80.1	14.2
13	Архивын ерөнхий газар	73.7	80.1	6.4
14	Жижиг, дунд үйлдвэрийн газар	90.1	79.5	-10.6
15	Ойн газар	-	78.8	-
16	Соёл, урлагийн газар	62.9	77.3	14.4
17	Онцгой байдлын ерөнхий газар	70	76.2	6.2
18	Татварын ерөнхий газар	68.1	75.8	7.7
19	Ашигт малтмал, газрын тосны газар	76.8	75.8	-1.0
20	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	65.6	75.7	10.1
21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	76.8	75.7	-1.1
22	Үндэсний геологийн алба	82.3	75.6	-6.7
23	Оюуны өмчийн газар	70.2	75.2	5.0
24	Цагдаагийн ерөнхий газар	69.4	75.0	5.6
25	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар	-	70.3	-
26	Усны газар	78.8	68.0	-10.8
27	Мал эмнэлгийн ерөнхий газар	71	67.6	-3.4
28	Биеийн тамир, спортын улсын хороо	75	64.7	-10.3
29	Цаг уур, орчны шинжилгээний газар	63.9	62.2	-1.7
30	Гаалийн ерөнхий газар	56.4	61.9	5.5
31	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	70.7	61.1	-9.6
32	Иргэний нисэхийн ерөнхий газар	68.7	57.7	-11.0
33	Нийгмийн даатгалын ерөнхий газар	81.8	56.5	-25.3

ЗДТГ-уудын БОУ-ний дундаж 68.7 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 3.2 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт юм. ЗДТГ-уудаас “Өвөрхангай аймгийн ЗДТГ” хамгийн өндөр оноо авч нэгдүгээрт орсон. Хоёрдугаарт “Орхон аймгийн ЗДТГ”, гуравдугаарт “Говь-Алтай аймгийн ЗДТГ” дөрөвдүгээрт “Сүхбаатар аймгийн ЗДТГ” тавдугаарт “Нийслэлийн ЗДТГ” эрэмбэлэгджээ. Эхний тавдугаарт эрэмбэлэгдсэн ЗДТГ-уудаас “Орхон аймгийн ЗДТГ”-ын оноо буурсан үзүүлэлттэй байна.

“Өвөрхангай аймгийн ЗДТГ”-ын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ, “Орхон аймгийн ЗДТГ” болон “Говь-Алтай аймгийн ЗДТГ”-ын авлигыг хянах механизмын оноо хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн. “Орхон аймгийн ЗДТГ”-ын авлигын бодит тохиолдол болон удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзлийн оноо буурчээ.

2023 оны БОУ-ээр 8 ЗДТГ-ийн үнэлгээ дунджаар 6.9 оноогоор буурсан байна. Хамгийн их буюу 15.9 оноогоор “Увс аймгийн ЗДТГ” -ын үнэлгээ буурчээ. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудаас хамгийн сүүлд Увс аймгийн ЗДТГ, Ховд аймгийн ЗДТГ, Баян-Өлгий аймгийн ЗДТГ эрэмбэлэгджээ. Увс аймгийн ЗДТГ-ын хувьд байгууллагын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ хамгийн ихээр буурсан. Харин “Баян-Өлгий аймгийн ЗДТГ” болон “Ховд аймгийн ЗДТГ”-ын авлигын бодит тохиолдлын оноо хамгийн олон оноогоор нэмэгджээ.

Хүснэгт 22. ЗДТГ - уудын БОУ, 2022, 2023 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2022	2023	Өөрчлөлт
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ	65.5	68.7	3.2
1	Өвөрхангай аймгийн ЗДТГ	67.1	76.4	9.3
2	Орхон аймгийн ЗДТГ	74.9	74.2	-0.7
3	Говь-Алтай аймгийн ЗДТГ	63.7	74.1	10.4
4	Сүхбаатар аймгийн ЗДТГ	61.7	74.0	12.3
5	Нийслэлийн ЗДТГ	71.2	73.6	2.4
6	Баянхонгор аймгийн ЗДТГ	63.9	73.5	9.6
7	Дорнод аймгийн ЗДТГ	62.6	73.3	10.7
8	Дорноговь аймгийн ЗДТГ	79.2	73.3	-5.9
9	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	63.7	73.0	9.3
10	Архангай аймгийн ЗДТГ	53.3	72.1	18.8
11	Дундговь аймгийн ЗДТГ	68.5	69.9	1.4
12	Дархан-Уул аймгийн ЗДТГ	69.5	68.4	-1.1
13	Булган аймгийн ЗДТГ	66.7	67.4	0.7
14	Хөвсгөл аймгийн ЗДТГ	56.2	66.7	10.5
15	Өмнөговь аймгийн ЗДТГ	70.3	66.3	-4.0
16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	53.4	66.0	12.6
17	Төв аймгийн ЗДТГ	68.6	65.6	-3.0
18	Завхан аймгийн ЗДТГ	77.9	64.7	-13.2
19	Хэнтий аймгийн ЗДТГ	74	62.5	-11.5
20	Увс аймгийн ЗДТГ	75.7	59.9	-15.8
21	Ховд аймгийн ЗДТГ	54.2	59.0	4.8
22	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	45.3	56.8	11.5

3.4.1. БОУ, дэд үзүүлэлтээр

БОУ-ний судалгаанд оролцогчдын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 76.4 болж 2022 онтой харьцуулахад 2.7 оноогоор нэмэгджээ. Энэхүү үзүүлэлт 2016 оноос хойш тасралтгүй өсөж байгаа төдийгүй БОУ-ний дунджаас 2.7 оноогоор илүү байна. Энэхүү дэд үзүүлэлтийн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн байгууллагууд нь “Эрүүл мэндийн яам” (35.8 оноогоор өссөн), “Хууль зүй, дотоод хэргийн яам” (31.6 оноогоор өссөн), “Архангай аймгийн ЗДТГ” (30.5 оноогоор өссөн) юм.


Авлигыг хянах механизмын үнэлгээ 56.5 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 8.5 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд 2019 оноос хойш тасралтгүй буурч байсан нь энэ онд сайжирчээ. Авлигыг хянах механизмын үнэлгээ бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн бага үнэлгээтэй хэдий ч 2022 оны үнэлгээтэй харьцуулахад хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байна. Авлигыг хянах механизмыг илэрхийлэх үзүүлэлтүүдээс “Байгууллага дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог” гэсэн үзүүлэлт хамгийн олон оноогоор нэмэгджээ. Энэхүү дэд үзүүлэлтийн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн байгууллагууд нь “Стандарт, хэмжил зүйн газар” (40.2 оноогоор өссөн), “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” (37.4 оноогоор өссөн), “Онцгой байдлын ерөнхий газар” (32.5 оноогоор өссөн) юм.

Авлигын бодит тохиолдол хамгийн өндөр 97.5 буюу БОУ-ны дунджаас 23.8 оноогоор илүү байна. Энэхүү дэд үзүүлэлтийн хувьд 2016-2021 онд тасралтгүй өссөн үзүүлэлттэй байсан ч 2022 онд буурч, 2023 онд өсчээ. Авлигын бодит тохиолдлын үнэлгээний өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн байгууллагууд нь “Байгаль орчин, аялал жуулчлалын яам” (24.5 оноогоор өссөн), “Гаалийн ерөнхий газар” (19.4 оноогоор өссөн), “Хөвсгөл аймгийн ЗДТГ” (18.2 оноогоор өссөн) юм.

Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 64.4 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 4.6 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэхүү дэд үзүүлэлт нь 2016-2022 онд тасралтгүй өсөж байсан ч 2022 онд буурч, 2023 онд нэмэгдсэн байна. Удирдлагын авлигатай тэмцэх хүслийн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн байгууллагууд нь “Байгаль орчин, аялал жуулчлалын яам” (32.5 оноогоор өссөн), “Архангай аймгийн ЗДТГ” (32.0 оноогоор өссөн), “Эрүүл мэндийн яам” (25.8 оноогоор өссөн) юм.

Доорх 4 дэд үзүүлэлтийн хувьд ерөнхийдөө 2022 онд буурах хандлагатай байсан ч 2023 онд нэмэгдсэн буюу бодлогод оролцогчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа сайжирсан байна.


График 27. БОУ, оноогоор, дэд үзүүлэлтээр



Дэд үзүүлэлт бүр дээр яамдын үнэлгээ хамгийн сайн буюу БОУ-ний дунджаас 3.6 оноогоор өндөр байгаа бол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үнэлгээ 68.7 буюу БОУ-ний дунджаас 5.0 оноогоор доогуур байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигыг хянах механизмын үнэлгээ дунджаас 7.2 оноогоор бага байгаа нь хамгийн өндөр зөрүүтэй (муу) үнэлгээ юм. Энэхүү үзүүлэлтийг илэрхийлэх асуултуудаас “Байгууллага дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог” гэсэн үзүүлэлт 2023 оны үнэлгээний дунджаас хамгийн олон онооны зөрүүтэй (муу) байна. Өөрөөр хэлбэл аймаг нийслэлийн ЗДТГ-уудын авлигыг хянах механизм тэр дундаа дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцох нь бусад төрийн байгууллагуудаас муу байна.

Яамдын хувьд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан” байдал хамгийн өндөр оноогоор нэмэгдсэн бол агентлагуудын хувьд “Байгууллага дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог” гэсэн үзүүлэлт хамгийн олон оноогоор нэмэгджээ.

График 28. БОУ, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр



Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ яамдаас “Эрүүл мэндийн яам” (35.8 оноогоор өссөн), агентлагуудаас “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар” (20.8 оноогоор өссөн), ЗДТГ-уудаас “Архангай аймгийн ЗДТГ” (30.5 оноогоор өссөн) хамгийн олон оноогоор нэмэгджээ.

Авлигыг хянах механизмын үнэлгээ яамдаас “Гадаад харилцааны яам” (32.8 оноогоор өссөн), агентлагуудаас “Стандарт, хэмжил зүйн газар” (40.2 оноогоор өссөн), ЗДТГ-уудаас “Өмнөговь аймгийн ЗДТГ” (21.2 оноогоор өссөн) хамгийн олон оноогоор нэмэгджээ.

Авлигыг бодит тохиолдлын үнэлгээ яамдаас “Байгаль орчин, аялал жуулчлалын яам” (24.5 оноогоор өссөн), агентлагуудаас “Гаалийн ерөнхий газар” (19.4 оноогоор өссөн), ЗДТГ-уудаас “Хөвсгөл аймгийн ЗДТГ” (18.2 оноогоор өссөн) хамгийн олон оноогоор нэмэгджээ.

Удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үнэлгээ яамдаас “Байгаль орчин, аялал жуулчлалын яам” (32.5 оноогоор өссөн), агентлагуудаас “Гадаадын иргэн, харьяатын газар” (22.2 оноогоор өссөн), ЗДТГ-уудаас “Архангай аймгийн ЗДТГ” (32.1 оноогоор өссөн) хамгийн олон оноогоор нэмэгджээ.

3.4.2. Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ


Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ-ний дундаж 73.6 байгаа 2022 оны тус үнэлгээнээс 2.9-өөр өссөн бөгөөд энэ оны БОУ-ний үнэлгээний дунджаас 0.1-ээр бага байв. Дүүргүүдийн ЗДТГ-ын дундаж үнэлгээнээс доогуур үнэлэгдсэн гурван дүүргийн ЗДТГ байна.

Дүүргийн ЗДТГ-уудын БОУ-ээр нэгдүгээрт “Сүхбаатар дүүргийн ЗДТГ”, хоёрдугаарт “Баянзүрх дүүргийн ЗДТГ”, гуравдугаарт “Чингэлтэй дүүргийн ЗДТГ” эрэмбэлэгджээ. “Сүхбаатар дүүргийн ЗДТГ”, “Баянзүрх дүүргийн ЗДТГ”-ын авлигыг хянах механизм (СБД-17.7, БЗД-15.7), “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (2.7) хамгийн олон оноогоор нэмэгджээ.

Хамгийн сүүлд “Хан-Уул дүүргийн ЗДТГ”, “Багануур дүүргийн ЗДТГ”, “Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ” эрэмбэлэгдсэн. “Хан-Уул дүүргийн ЗДТГ”-ын хувьд авлигын талаарх төсөөлөл болон удирдлагын авлигатай тэмцэх хүсэлтэй холбоотой үзүүлэлт буурсан нь энэхүү эрэмбэд хамгийн ихээхэн нөлөөлсөн байв.

Нийт 9 дүүргийн ЗДТГ судалгаанд хамрагдсанаас 3 дүүрэг дунджаас доогуур, 6 дүүрэг дунджаас дээгээр үнэлгээ авчээ.

График 29. Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ




Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ нийт аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээнээс 4.9 оноогоор өндөр байна.

Дүүргүүдийн ЗДТГ-ын авлигыг хянах механизм 54.5, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 64.6-аар үнэлэгдсэнээс харахад дүүргүүдийн ЗДТГ-ын авлигыг хянах механизмыг сайжруулж, удирдлагын авлигатай тэмцэх хүслийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.


Авлигын бодит тохиолдол болон удирдлагын авлигатай тэмцэх хүслийг илэрхийлэх асуултуудын үнэлгээ өөр хоорондоо ерөнхийдөө ойролцоо байна. Харин авлигын талаарх төсөөллийг илэрхийлэх асуултуудаас “Албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах/шан харамж шаардах явдал гардаг эсэх” гэсэн үзүүлэлт хамгийн бага (37.3)-аар үнэлэгджээ. Энэ асуултын тухайд “Налайх дүүргийн ЗДТГ” (85.9)-аас бусад дүүргийн ЗДТГ-ууд 40.0-өөс бага оноогоор үнэлэгдсэн байна. Авлигыг хянах механизмыг илэрхийлэх асуултуудаас “Байгууллага дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог” гэсэн үзүүлэлт хамгийн бага 48.5 оноогоор үнэлэгджээ.

График 30. Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ, дэд үзүүлэлтээр



Дэд үзүүлэлтүүдийг дүүргээр задлан харвал, авлигын талаар төсөөллийн хамгийн бага үнэлгээг “Хан-Уул дүүргийн ЗДТГ”, авлигыг хянах механизмын хамгийн бага үнэлгээг “Багахангай дүүргийн ЗДТГ”, авлигын бодит тохиолдлын хамгийн бага үнэлгээг “Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ”, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийн хамгийн бага үнэлгээг “Багануур дүүргийн ЗДТГ” авсан байна.

График 31. Дүүргийн ЗДТГ-ын БОУ, дэд үзүүлэлтээр, байршлаар



Авлигын талаарх төсөөллийг илэрхийлэх үзүүлэлтүүдээс “Хан-Уул дүүргийн ЗДТГ”-ын “Албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах/шан харамж шаардах” гэсэн үзүүлэлт өмнө оноос хамгийн ихээр буурч хамгийн бага үнэлгээг авсан нь тухайн дүүрэг энэ үзүүлэлтэд хамгийн бага оноог авахад нөлөөлжээ.

Авлигыг хянах механизмын үнэлгээ “Багахангай дүүргийн ЗДТГ”-т хамгийн бага байгаа нь “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан” гэсэн үзүүлэлтийн үнэлгээ буурсантай холбоотой.

Авлигын бодит тохиолдол “Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ”-т хамгийн бага үнэлгээтэй байгаа нь “Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйлс авсан” гэсэн үзүүлэлтийн оноо буурсантай холбоотой байна.

Харин “Багануур дүүргийн ЗДТГ”-ын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл хамгийн бага үнэлгээ авахад тухайн байгууллагын удирдлага болон дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийн үнэлгээ буурсантай холбоотой байв.

БҮЛЭГ 4. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Энэхүү бүлэгт Монгол Улс дах авлигын шалтгаан, нөхцөл, авлига хамгийн их тархсан институцийн талаар болон ирэх 2 жил авлигын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөллийг харуулсан үр дүнг орууллаа.


4.1. Монгол Улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын авлигын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хэр түгээмэл байна вэ? гэсэн асуултаар тодруулсан ба хариултуудын хувьд ихээхэн түгээмэл, түгээмэл, дунд зэрэг, бага, огт байхгүй, мэдэхгүй гэсэн хариултуудын үр дүнг авч нэгтгэсэн.

Судалгаанд оролцогчын дийлэнх хувь нь буюу 74.2 хувь нь Монгол Улсад авлига ихээхэн түгээмэл болон түгээмэл байдаг гэж хариулжээ. Энэ нь 2021 онтой харьцуулахад 6.6 пунктээр нэмэгджээ.

Судалгаанд оролцогчдоос төлөөллөөс Монгол Улсад авлига яагаад түгээмэл байгааг тодруулахад одоогийн нийгэм, төрийн тогтолцоо буруу байгаа учраас түгээмэл байна гэж үзэж байна. Мөн төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их авдаг, төрийн албан хаагчдын хүнд суртал маш их байдаг учраас хүмүүс ажлаа хурдан бүтээх гэж, цаг хугацаа хэмнэх, одоогийн байгаа хууль дүрэм, журам хэрэгждэггүй, авлига, өгсөн авсан хүнд аль алинд нь хариуцлага тооцдоггүй тогтолцоо байсаар байгаа нь авлига түгээмэл байгаагийн нэг гол илрэл юм гэж дурдаж байв.


График 32. Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, оноор, нийт оролцогчдын хувьд



Судалгаанд оролцсон 10 иргэн, бодлогод оролцогч тутмын 7.6 нь, 10 төрийн албан хаагч тутмын 7 нь Монгол Улсад авлига түгээмэл байна гэж үзжээ. Тодруулбал, судалгаанд хамрагдсан бодлогод оролцогчдын 76.6 хувь нь, төрийн албан хаагчдын 69.5 хувь, иргэд (үйлчлүүлэгч)-ийн 76.7 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл буюу ихээхэн түгээмэл байна гэж хариулжээ.

Бодлогод оролцогч, иргэд, албан хаагчдын хувьд Монгол Улсад авлига түгээмэл буюу ихээхэн түгээмэл гэж үзэх нь өмнө онуудаас өссөн үзүүлэлттэй байна.

График 33. Монгол Улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, судалгаанд оролцогчдын төрлөөр, оноор



4.2. Авлига хамгийн их тархсан институц

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад дийлэнх нь “Шүүх” гэж хариулжээ. Үүний дараа Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага, Гаалийн байгууллага, Улс төрийн нам эрэмбэлэгдэж байна. Энэхүү үр дүнг 2022 онтой харьцуулахад эрэмбэ нь бага зэргийн өөрчлөлт орсон бөгөөд авлига хамгийн их тархсан байгууллагуудын авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна. Мөн судалгааны үр дүнг дүгнэн үзэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд эдгээр байгууллагуудад бий болсон авлигыг бууруулах чиглэлд ахиц гарсан ажил хийгдээгүй гэж үзэхээр байна.

Хүснэгт 23. Авлига хамгийн их тархсан институц, оноор, нийт оролцогчдын хувьд

№	Төрөл	2018	2019	2021	2022	2023
1	Шүүх	49.20%	53.30%	48.00%	50.50%	59.00%
2	Газрын алба	47.00%	42.90%	41.80%	48.90%	55.00%
3	Эрүүл мэндийн байгууллага	46.40%	42.60%	48.30%	52.00%	49.60%
4	Гаалийн байгууллага	35.40%	48.00%	36.90%	46.40%	47.10%
5	Улс төрийн нам	35.80%	33.70%	30.50%	34.20%	44.50%
6	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	43.90%	35.00%	31.70%	36.20%	39.00%
7	Прокурорын байгууллага	29.90%	33.20%	29.80%	30.00%	36.50%
8	Цагдаагийн байгууллага	38.20%	33.90%	35.30%	41.60%	35.30%
9	Боловсролын байгууллага	41.00%	32.90%	32.70%	37.10%	34.30%
10	Нутгийн захиргааны байгууллага	25.80%	19.60%	22.20%	26.10%	28.00%
11	Хэвлэл мэдээллийн байгууллага	15.90%	19.50%	16.10%	22.80%	27.20%
12	Татварын байгууллага	25.20%	26.70%	26.50%	28.80%	23.20%
13	Мэргэжлийн хяналтын байгууллага	33.90%	44.60%	33.40%	39.70%	18.4%
14	Хувийн хэвшил	10.40%	6.50%	10.50%	9.90%	11.00%
15	Төрийн бус байгууллага	10.80%	6.60%	11.60%	11.20%	10.00%
16	Бусад	3.30%	-	0.10%	0.20%	3.70%
17	Мэдэхгүй	-	-	5.50%	1.90%	2.70%
18	Байхгүй	-	-	0.50%	0.90%	0.10%

Иргэдийн хувьд судалгаанд хамрагдагсдын 60.8 хувь нь шүүх, 55.5 хувь нь эрүүл мэндийн байгууллага, 54.8 хувь нь газрын алба, 46.2 хувь нь улс төрийн яам, 44.6 хувь нь төрийн захиргааны байгууллага яам, агентлагуудад авлига хамгийн түгээмэл тархсан гэж үзэж байна. Түүнчлэн мэдэхгүй, хариулахаас татгалзсан хариултыг сонгох болсон шалтгааныг тодруулахад аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийн хувьд ямар нэгэн асуудалд орохыг хүсэхгүй байсан учраас хариулахаас татгалзсан байна. Харин бүх түвшний оролцогчдын хувьд авлига авч, өгч байсан удаа байхгүй, тийм тохиолдлыг харж байгаагүй учраас авлига хэр түгээмэл байгаад үнэлгээ өгч “мэдэхгүй” гэж хариулсан байна.

Хүснэгт 24. Монгол Улс дахь авлига хамгийн их тархсан институт, 2023

№	Байгууллагын нэр	2019	2020	2021	2022	2023
1	Шүүх	49.2%	53.3%	48.0%	51.4%	60.8%
2	Эрүүл мэндийн байгууллага	46.4%	42.6%	48.3%	52.2%	55.5%
3	Газрын алба	47.0%	42.9%	41.8%	44.6%	54.8%
4	Улс төрийн нам	35.8%	33.7%	30.5%	39.1%	46.2%
5	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	43.9%	35.0%	31.7%	42.5%	44.6%
6	Гаалийн байгууллага	35.4%	48.0%	36.9%	35.3%	44.4%
7	Цагдаагийн байгууллага	38.2%	33.9%	35.3%	37.1%	43.2%
8	Прокурорын байгууллага	29.9%	33.2%	29.8%	32.0%	39.9%
9	Боловсролын байгууллага	41.0%	32.9%	32.7%	41.1%	39.3%
10	Нутгийн захиргааны байгууллага	25.8%	19.6%	22.2%	33.6%	31.1%
11	Хэвлэл мэдээллийн байгууллага	15.9%	19.5%	16.1%	27.5%	28.3%
12	Татварын байгууллага	25.2%	26.7%	26.5%	31.9%	23.5%
13	Мэргэжлийн хяналтын байгууллага	33.9%	44.6%	33.4%	38.9%	20.3%
14	Хувийн хэвшил	10.4%	6.5%	10.5%	16.8%	13.5%
15	Төрийн бус байгууллага	10.8%	6.6%	11.6%	15.5%	12.3%
16	Мэдэхгүй	-	-	5.5%	0.7%	3.2%
17	Байхгүй	-	-	0.5%	0.6%	0.2%
18	Бусад	3.3%	-	0.1%	0.5%	0.1%

Албан хаагчдын хувьд судалгаанд хамрагдагсдын 60.8 хувь нь шүүх байгууллага, 55.5 хувь нь эрүүл мэндийн байгууллага, 54.8 хувь нь газрын алба, 46.2 хувь нь улс төрийн нам, 44.6 хувь нь төрийн захиргааны байгууллага яам агентлагт авлигал хамгийн түгээмэл тархсан гэж үзэж байна. Судалгаанд оролцогчдын хувьд улс төр, намын нөлөө, томилгоо, хууль эрх зүйн орчин муу, хэрэгжилт сул, төрийн үйлчилгээний хүртээмжгүй байдал, хувийн ашиг сонирхлоо өмнөө тавьдаг зэрэг нь шүүх байгууллагад авлига их тархсан гэж үзэх шалтгаан нь болжээ. Харин эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмжгүй байдал, ачаалал, цалин хөлсний хэмжээ бага байдаг нь үйлчлүүлэгчдийн бухимдлыг ихээхэн төрүүлдэг байна

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад дийлэнх нь “Шүүх”, “Газрын алба”, “Гаалийн байгууллага”, “Эрүүл мэндийн байгууллага”, “Улс төрийн нам” гэж хариулсан байна. Энэхүү үр дүнг 2022 онтой харьцуулахад “Газрын алба” 1.5 пунктээр өссөн, “Эрүүл мэндийн байгууллага” 3.9 пунктээр буурсан, “Улс төрийн нам” 2.1 пунктээр өссөн, “Гаалийн байгууллага” 0.5 пунктээр буурсан, харин “Шүүхийн байгууллага” хамгийн их буюу 4.6 пунктээр өсөж нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 25. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор

№	Төрөл	2022 оны эрэмбэ	2023 оны эрэмбэ	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ
1	Шүүх	2	1	50.0%	54.6%
2	Газрын алба	1	2	50.8%	52.3%
3	Гаалийн байгууллага	5	3	48.4%	47.9%
4	Эрүүл мэндийн байгууллага	3	4	49.6%	45.7%
5	Улс төрийн нам	6	5	39.0%	41.1%
6	Боловсролын байгууллага	7	6	31.3%	31.5%
7	Прокурорын байгууллага	8	7	28.8%	29.6%
8	Цагдаагийн байгууллага	9	8	27.8%	26.9%
9	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	11	9	26.0%	26.7%
10	Хэвлэл мэдээллийн байгууллага	12	10	23.7%	24.9%
11	Татварын байгууллага	10	11	27.5%	23.4%
12	Нутгийн захиргааны байгууллага	13	12	18.7%	20.1%
13	Мэргэжлийн хяналтын байгууллага	4	13	49.4%	18.9%
14	Хувийн хэвшил	15	14	6.4%	7.8%
15	Төрийн бус байгууллага	14	15	6.5%	7.5%
16	Бусад	16	16	4.5%	5.6%

Албан хаагчид дээрх хүснэгтэд онцолсон 5 байгууллагыг авлига хамгийн их тархсан институц хэмээн онцлох болсон нь тэдэнд өдөр тутам тулгамдаж буй асуудлаас шалтгаалсан байна.

Шүүхийн байгууллагыг авлига хамгийн их тархсан институц хэмээн онцолсон шалтгааныг тодруулахад шүүгч нар шийдвэрлэж буй хэргийн мөн чанарыг илэрхийлэх үнэн бодит байдлыг харгалзан үзэж хэргийг шийдвэрлэхээс илүү хэн нэгэн хүний ашиг сонирхолд нийцүүлэн хуулийг хэрэглэж, эрх мэдлээ урвуулан ашигладаг тохиолдол нэлээдгүй байдагтай холбоотой байв.

Газрын албын авлига хамгийн их тархсан институц хэмээн онцолсон шалтгааныг тодруулахад тухайн байгууллагын албан хаагчдын хүртээмжгүй байдал, ачаалал зэргээс хамааран үйлчлүүлэгчид ажлаа түргэн хугацаанд бүтээх гэж мөнгө, төгрөг, бэлэг, сэлт өгдөг, үүнийг уламжлал болсон зүйл гэж андууран албан хаагчид “гар харах” байдал түгээмэл байдагтай холбоотой гэж тайлбарлажээ.

Гаалийн байгууллагыг авлига хамгийн их тархсан институц хэмээн онцолсон шалтгааныг тодруулахад гаалийн байцаагчид авлигал өгсөн хүний гаалийн бүрдүүлэлтийг хамгийн түрүүнд хийж өгдөг, үүнийг хянах, илрүүлэх дотоод хяналт сул байдагтай холбоотой гэж судалгаанд оролцогчид дурдсан байв.

Эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмжгүй байдал, ачаалал, цалин хангамж хүрэлцээгүй байдаг нь үйлчлүүлэгчдийн бухимдлыг ихээхэн төрүүлдэг билээ. Мөн үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ бэлэг сэлт өгөхгүй бол чанартай үйлчилгээ авч чадахгүй гэж боддог, шаардлага хангалттай тавьдаггүй зэрэг зан төлөв нь энэ салбарыг авлига их тархсан гэж үзэхэд нөлөөлж байна. Хамгийн бодит жишээ бол жирэмсэн эхчүүд төрөх эмнэлэгт очиход эмч, сувилагч, асрагч нарт гарыг нь цайлгах мөнгө өгөхгүй бол загнах, анхаарал бага хандуулах, анхлан төрөгчид шаардлагатай заавар, зөвлөгөөг өгөхгүй байх зэргээр нялх биетэй эхчүүдийг сэтгэл санааны дарамтанд оруулдаг. Үүнээс шалтгаалан зарим боломжтой эхчүүд өндөр төлбөртэй хувийн эмнэлэгт амаржихыг илүүд үздэг болсон байна.

Улс төрийн намыг авлига хамгийн их тархсан институц хэмээн онцолсон шалтгааныг тодруулахад ажил, албан тушаалд томилох, албан тушаал, эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх, эдгээрийг даган нийтийн эд хөрөнгийг төрөл бүрээр завших болон сонгогчдын саналыг худалдан авах явдал, намын санхүүжилтийн механизм, сонгуулийн санхүүжилтийн механизм, шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил гэх мэт зүйлс голлох үүрэг гүйцэтгэж байна.

Бодлогод оролцогчдын хувьд судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад 61.8 хувь нь “Шүүхийн байгууллага” гэжээ. Энэ нь өмнөх үнэлгээтэй харьцуулахад 11.6 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт юм.

“Газрын алба” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.5 пунктээр нэмэгдэж хоёрдугаарт эрэмбэлэгдсэн бол гуравдугаарт 48.9 хувиар “Гаалийн байгууллага”, дөрөвдүгээрт 47.6 хувиар “Эрүүл мэндийн байгууллага” оржээ.

Бодлогод оролцогч шинжээчдийн үзэж буйгаар авлигатай холбоотой олон хэрэг илэрч байгаа ч тухайн хэргийг шүүхээр шийдвэрлэж чаддаггүй, удаадаг төдийгүй олон нийтэд ил болсон хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл хийдэггүй гэжээ. Түүнчлэн шүүх байгууллага гаднын нөлөөнд (эрх мэдэл, авлига г.м) ихээхэн автдаг бөгөөд энэ нь нийгмийн гажуудлыг үүсгэж байна. Зарим шинжээчид авлигатай холбоотой хэргийг олон нийтэд нээлттэйгээр шийдвэрлэх шаардлагатай гэж үзжээ.

Хүснэгт 26. Монгол Улсад авлига их тархсан институц, оноор


№	Төрөл	2022	2023	2022	2023
		оны эрэмбэ	оны эрэмбэ	оны үнэлгээ	оны үнэлгээ
1	Шүүх	3	1	50.20%	61.77%
2	Газрын алба	2	2	52.50%	57.98%
3	Гаалийн байгууллага	4	3	47.20%	48.99%
4	Эрүүл мэндийн байгууллага	1	4	52.90%	47.63%
5	Улс төрийн нам	8	5	39.50%	46.26%
6	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	5	6	42.80%	45.71%
7	Прокурорын байгууллага	10	7	28.90%	39.49%
8	Цагдаагийн байгууллага	9	8	35.20%	35.81%
9	Нутгийн захиргааны байгууллага	12	9	22.70%	32.73%
10	Боловсролын байгууллага	6	10	41.10%	32.12%
11	Хэвлэл мэдээллийн байгууллага	13	11	22.10%	28.48%
12	Татварын байгууллага	11	12	28.50%	22.78%
13	Мэргэжлийн хяналтын байгууллага	7	13	41.00%	16.11%
14	Хувийн хэвшил	15	14	7.90%	11.82%
15	Төрийн бус байгууллага	14	15	10.30%	10.30%
16	Бусад	16	16	2.40%	5.40%
17	Мэдэхгүй	17	17	0.00%	2.22%
18	Байхгүй	18	18	0.00%	0.00%

4.3. Монгол Улс дах авлигын шалтгаан

Судалгаанд оролцогчдоос иргэд болон ААНБ-ын хувьд Монгол улс дахь авлигын үндсэн шалтгааныг та юу гэж бодож байна вэ? Гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 23.8 хувь нь цалин, хөлсний хэмжээ бага, амьжиргааны түвшин доогуур, 14.7 хувь нь хууль эрх зүйн орчин муу, 12.1 хувь нь хүнд суртал, 10.7 хувь нь хүмүүсийн ухамсар, хандлага, сэтгэлгээ, 9.8 хувь нь улс төр, намын нөлөө, томилгоо, 9.2 хувь нь эрх мэдэл, албан тушаалд шунах, хэтрүүлэн ашиглах, 8.2 хувь нь амар хялбараар ажил бүтээхийн тулд, 8.2 хувь нь танил талаа ашигласнаас болж, 6.4 хувь нь ядуурал, 6.2 хувь нь мэдэхгүй байна гэх


мэтчилэн хариулжээ. Мөн 2022 онд судалгаанд оролцогчдын 18.1 хувь нь мэдэхгүй гэж хариулж байсан бол 2023 онд 6.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

График 34. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, иргэд ААНБ



Албан хаагчдын хувьд Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад 27.0 хувь нь цалин, хөлсний хэмжээ бага, амьжиргааны түвшин муу, 12.9 хувь нь хууль эрх зүйн орчин мээ хэрэгжилт сул, 11.9 хувь нь хүмүүсийн ухамсар хандлага, 10.7 хувь нь хүнд сурталтай холбоотой хэмээн хариулжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын 4.5 хувь нь энэ талаар хэлж мэдэхүй байна гэж хариулсан байв.

График 35. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, төрийн албан хаагчид




Судалгаанд оролцогчдын хариултын хувийг байгууллагын төрлөөр нь нарийвчлан авч үзвэл албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг гэж хариулсан оролцогчдын дийлэнх нь яам, агентлагийн төлөөлөл байсан бол цалин, орлого бага гэж хариулсан оролцогчид аймаг, нийслэлийн ЗДТГ-ын төлөөлөл давамгайлж байсан.

Мөн авлигыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий байгууллагууд томоохон хэргүүдийг онцлон авч үзэж шийдвэрлэдэг боловч үүний цаана

нуугддаг маш олон жижиг авлигатай холбоотой хэргийг анзаардаггүй, арга хэмжээ авдаггүй нь төрийн байгууллагуудын авлигыг бууруулахад ахиц дэвшил гаргаж чадахгүй байна гэж судалгаанд оролцогчид хариулж байсан юм.

График 36. Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан, бодлогод оролцогч шинжээчид



Бодлогод оролцогч шинжээчдээс Монгол Улс дахь авлигын шалтгааныг тодруулахад 27.2 хувь нь албан хаагчид эрх мэдлээ урвуулан ашиглаж, ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг,

26.3 хувь нь цалингийн хэмжээ бага, иргэдийн амьжиргааны түвшин доогуур, 18.9 хувь нь хууль эрх зүйн орчин, хэрэгжилт муу байгаатай холбон тайлбарлажээ.

Судалгаанд оролцогчдын хариултын хувийг нэгтгэн дүгнэвэл албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг гэж хариулсан оролцогчдын дийлэнх нь яам, агентлагийн төлөөлөл байсан бол цалин, орлого бага гэж хариулсан оролцогчид аймаг, нийслэлийн ЗДТГ-ын төлөөлөл давамгайлж байсан.

Мөн авлигыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий байгууллагууд томоохон хэргүүдийг онцлон авч үзэж шийдвэрлэдэг боловч үүний цаана нуугддаг маш олон жижиг авлигатай холбоотой хэргийг анзаардаггүй, арга хэмжээ авдаггүй нь төрийн байгууллагуудын авлигыг бууруулахад ахиц дэвшил гаргаж чадахгүй байна гэж судалгаанд оролцогчид хариулж байсан юм.

4.4. Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын талаар оролцогчдын санал

Иргэд ААНБ-ын хувьд тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд та юу хийх шаардлагатай байна вэ? Гэсэн асуултад 11.6 хувь нь мэдээллийг ил тод, шилэн болгох, 11.7 хувь нь сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, 7.4 хувь нь үнэнч шударга ажиллах, 7.0 хувь цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлэх, 6.9 хувь нь хяналт, шалгалтыг сайжруулах, 4.4 хувь нь хариуцлагын тогтолцоог сайжруулах, 4.2 хувь нь хууль, дүрэм журмыг сайжруулах, 3.2 хувь нь цахимжуулах гэх мэтээр хариулсан байна.


Хүснэгт 27. Тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд та юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?

№	Төрөл	Хувь
1	Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах	11.7%
2	Мэдээллийг ил тод, шилэн болгох	11.6%
3	Үнэнч шударга ажиллах	7.4%
4	Цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлэх	7.0%
5	Хяналт, шалгалтыг сайжруулах	6.9%
6	Хариуцлагын тогтолцоог сайжруулах	4.4%
7	Хууль, дүрэм журмыг сайжруулах	4.2%
8	Цахимжуулах	3.2%
9	Ёс зүй, ёс суртахуунтай байх	2.5%
10	Хууль, дүрэм журмын дагуу чин сэтгэлээсээ ажиллах	2.5%
11	Хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх	2.0%
12	Хувь хүний хандлага, ухамсрыг сайжруулах	1.7%
13	Боловсон хүчнийг чадавхжуулах /мэдлэг боловсролыг дээшлүүлэх/	1.7%
14	Үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах	1.5%
15	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сайжруулах	1.5%
16	Эрх тэгш, шударга байдлыг хангах	1.3%
17	Хүнд суртлыг багасгах	1.1%
18	Чадварлаг боловсон хүчнээр хангах	1.0%
19	Төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх	1.0%
20	Ажлын байрны чиг үүргийн дагуу ажиллах	0.9%
21	Танил талаа ашиглахгүй байх	0.8%
22	Авлига авахгүй байх	0.8%
23	Авлига өгөхгүй байх	0.7%
24	Бүтэц зохион байгуулалтаа сайжруулах	0.7%
25	Төсөв санхүүг нээлттэй ил тод болгох	0.6%
26	Сонгон шалгаруулалтыг ил тод явуулах	0.6%
27	Ажиллах нөхцөлийг сайжруулах	0.6%
28	Улс төрийн томилгоо, намаас ангид байх	0.5%
29	Залуучуудыг дэмжиж ажиллах	0.4%
30	Санал хүсэлтийг сонсож байх	0.2%
31	Судалгаа явуулах	0.1%

№	Төрөл	Хувь
32	Уялдаа холбоог сайжруулах	0.04%
33	Одоо хийж байгаа үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийх	0.01%
34	Мэдэхгүй	13.7%
35	Байхгүй	2.5%
36	Саналгүй	1.9%
37	Бусад	0.5%


Иргэдийн хувьд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг нь багасгах, ажлын хуваарийг жигд болгох, мөн хүн амын нийгмийн хангамжийг сайжруулснаар авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлж чадах юм гэж ихэнх нь үзэж байна. Мөн хуулийн хэрэгжилт муу, үр дүн байдаггүй учраас хуулийг чангатгах, сайжруулах, хэрэгжүүлэх тал дээр сайн анхаарч ажиллах шаардлагатай, төрийн албан хаагчдын харилцаа муу, их зантай байдаг учраас төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, мөн хяналт шалгалт муу, ил тод, нээлттэй байдал тааруу байдаг учраас энэ тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгаа талаар мөн дурдаж байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

График 37. Авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд та юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?, албан хаагчдын хувьд



Албан хаагчдын хувьд авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд 28.9 хувь нь “сургалт сурталчилгаа соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, 18.4 хувь нь “мэдээллийг ил тод, нээлттэй болгох”, 6.0 хувь нь цалин хөлс хангамжийг нэмэгдүүлэх, 5.2 хувь нь хууль дүрэм журмын дагуу чин сэтгэлээсээ ажиллах, 5.0 хувь нь хяналтыг сайжруулах зэрэг ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай гэж үзжээ.

График 38. Бодлогод оролцогчдын үзэж байгаагаар авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлс



Авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд бодлогод оролцогч, шинжээчдийн 22.5 хувь нь сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, 18.4 хувь нь мэдээллийг ил тод, шилэн болгох, 8.0 хувь нь цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлэх, 7.1 хувь нь хяналтыг сайжруулах, 5.7 хувь нь хууль, дүрэм журмын дагуу чин сэтгэлээсээ ажиллах


хэрэгтэй гэж үзсэн байна. Судалгааны үр дүнг өнгөрсөн оны үр дүнтэй харьцуулахад, мэдээллийг ил тод, шилэн болгох гэж үзсэн хариултын хувь хамгийн их буюу 8.8 пунктээр нэмэгджээ.

4.5. Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл

Монгол Улсын ирэх 2 жилийн авлигын нөхцөл байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцогчдоос ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэр өөрчлөгдөх вэ? гэсэн асуултаар тодруулсан ба хариултуудын хувьд их өснө, өснө, өөрчлөгдөхгүй, буурна, их буурна, мэдэхгүй гэсэн хариултуудын үр дүнг авч нэгтгэсэн.


Судалгаанд оролцсон 10 оролцогч тутмын 4 нь ирэх 2 жилийн хугацаанд Монгол Улсад авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй хэмээсэн бол, 3 нь буурна буюу их буурна, 2 нь өснө буюу их өснө гэж үзсэн байна. Мөн судалгаанд оролцогчдоос мэдэхгүй, хариулахаас татгалзсан хариулт өгч буй шалтгааныг тодруулахад хувь хүмүүсийн хувьд Монгол улсад авлига их байгаа нь тодорхой болохоор цаашид юу болохыг мэдэхгүй, хариулахыг хүсэхгүй байна гэсэн хариултыг өгч байжээ.

График 39. Ирэх 2 жилд Монгол Улс дахь авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл, оноор, нийт оролцогчдын хувьд



Яагаад өөрчлөгдөхгүй гэж бодож байна вэ? гэдгийг лавлаж асуухад одоогийн нийгэм, төрийн тогтолцоо өөрчлөгдөж байж энэ нөхцөл байдал сайжрах учраас хоёрхон жилийн хугацаанд дорвитой өөрчлөлт гарахгүй гэж үзэж байсан хүмүүс олон байв. Мөн иргэдийн хувьд энэ тал дээр АТГ сайн ажиллах, АТГ авлигыг илрүүлж байгаа ч үр дүн муу байгаа талаар мөн дурдаж байв.

График 40. Ирэх 2 жилд Монгол Улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл, судалгаанд оролцогчдын төрлөөр, оноор




Мөн судалгаанд оролцогчид авлигаас ашиг хонжоо олдог учраас тэмцэх хүсэл эрмэлзэл байдаггүй, иймээс ирэх жилүүдэд авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй гэж тайлбарлаж байсан. Түүнчлэн мэдэхгүй, хариулахаас татгалзсан хариултыг сонгох болсон шалтгааныг тодруулахад аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийн хувьд ямар нэгэн асуудалд орохыг хүсэхгүй байсан учраас хариулахаас татгалзсан байна. Харин бүх түвшний оролцогчдын хувьд авлига авч, өгч байсан удаа байхгүй, тийм тохиолдлыг харж байгаагүй учраас авлига хэр түгээмэл байгаад үнэлгээ өгч “мэдэхгүй” гэж хариулсан байна.

БҮЛЭГ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Энэхүү бүлэгт “Авлигатай тэмцэх газар”-ын үйл ажиллагааны үр дүнгийн талаар орууллаа.


Судалгаанд оролцогчдоор АТГ-ын үйл ажиллагааг үнэлүүлж үр дүнг 2021 болон 2022 онтой харьцууллаа. Судалгаанд оролцогчдоор АТГ-ын үйл ажиллагааг үнэлүүлэхэд 10 оролцогч тутмын 4 нь АТГ-ын үйл ажиллагааг дунд зэрэг хэмээн үнэлсэн бол 3 нь үр ашигтай, 2 нь үр ашиггүй, үлдсэн 1 нь мэдэхгүй гэж хариулжээ.

График 41. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, оноор



АТГ-ын үйл ажиллагааны үнэлгээний хувьд иргэдийн 23.5 хувь, албан хаагчдын 30 хувь, бодлогод оролцогчдын 31.7 хувь нь тус тус АТГ-ын үйл ажиллагааг үр ашигтай гэж үзсэн бол иргэдийн 28.6 хувь, албан хаагчдын 16.9 хувь, бодлогод оролцогчдын 18,7 хувь нь тус тус үр ашиггүй гэж үнэлсэн байна.

График 42. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, судалгаанд оролцогчдын төрлөөр, оноор



Албан хаагч болон бодлогод оролцогчдын хувьд ихээхэн үр ашигтай, дунд зэрэг гэж үзсэн хариултын хувь нэмэгдсэн, харин үр ашигтай гэж хариулсан хариултын хувь буурчээ.

ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь ШБҮ-ний судалгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэн авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тэдгээрийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Шударга байдлын үнэлгээ

Энэ удаагийн судалгааны үр дүнгээр Шударга байдлын үнэлгээ 76.6 оноогоор үнэлэгдэж өмнөх оны үнэлгээний дүнгээс 2.7 оноогоор нэмэгджээ. Шударга байдлын үнэлгээ 2.7 оноогоор нэмэгдэхэд гадаад шударга байдлын үнэлгээ 2.3 оноогоор, бодлогод оролцогчдын үнэлгээ 4.7 оноогоор сайжирсан нь ихээхэн нөлөөлсөн байв.

Яамдын үнэлгээ ерөнхий дүнгээрээ 2022 онтой харьцуулахад 4.0 оноогоор нэмэгдсэн ба үнэлгээг эрэмбэлэхэд талаас илүү нь буюу 12 яам улсын дунджаас дээгүүр, үлдсэн 4 нь улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна. Нийт яамдаас 14 яамны үнэлгээ өмнөх үнэлгээтэй харьцуулахад өссөн, 2 яамны (Эдийн засаг хөгжлийн яам, Соёлын яам) үнэлгээ буурсан байна. Агентлагуудын үнэлгээ 2022 онтой харьцуулахад 2.8 оноогоор сайжирсан ба нийт 33 агентлаг судалгаанд хамрагдсанаас 19 агентлагийн үнэлгээ дунджаас дээгүүр, 14 агентлагийнх дунджаас доогуур түвшинд байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын 13 нь улсын дунджаас дээгүүр, 9 нь доогуур үнэлгээ авсан байв. Үнэлгээг 2022 онтой харьцуулахад 15 байгууллагынх нэмэгдэж, 7 байгууллагынх буурчээ. Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-уудын хувьд “Сүхбаатар дүүргийн ЗДТГ” хамгийн өндөр үнэлгээг авсан бол “Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ” хамгийн бага үнэлгээг авчээ. Дүүргүүдээс 5 нь дундаж үнэлгээнээс дээгүүр үнэлэгдсэн бол 4 нь дунджаас доогуур үнэлэгджээ.

ГШБҮ нь 2023 онд 72.8 болж өмнөх оноос 2.3 оноогоор өсөж, төрийн байгууллагуудын ил тод байдал буурч, хариуцлагатай байдал сайжирсан байна. Харин авлигын индекс өмнөх онтой харьцуулахад 5.3 оноогоор өсөж 82.4 үнэлгээ авчээ. Төрийн байгууллагуудын ГШБҮ-ээс харахад төрийн байгууллагын үйлчилгээ нэгж түвшиндээ буюу аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд жил болгон хамгийн бага үнэлгээ авдаг нь ЗДТГ-уудын үйл ажиллагаа шударга бус байгааг илэрхийлж байна. Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээнээс харахад аймаг, нийслэлийн хэмжээнд байгууллагын ил тод байдал болон ажилчдын хариуцлагатай байдал нь яамд, агентлагтай харьцуулахад доогуур байсан нь аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд энэ тал дээр анхаарч ажиллах шаардлагатайг илэрхийлж байна. Иргэд, аж ахуй нэгж байгууллагын хувьд төрийн байгууллагаар үйлчлүүлэхээсээ өмнө ихэнхдээ урьдчилж нэмэлт төлбөр, бэлэг, хандив өгөх сонирхолтой байна. Харин нэмэлт төлбөр, бэлэг, хандив өгөх гол шалтгаан нь төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их авдаг учраас ажлаа хурдан бүтээх гэж өгдөг байна. Иргэдийн хувьд төрийн байгууллагаар үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандивыг үйлчилгээ авахаас өмнө өгч байгаа бол байгууллагын төлөөлөл үйлчилгээ авч байхдаа өгдөг байдал нь өндөр байна.

ДШБҮ өмнөх онтой харьцуулахад 1.2 оноогоор өссөн бөгөөд ийнхүү өсөхөд соёлын индекс 0.5 оноогоор, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 1.1 оноогоор сайжирсан нь ихээхэн нөлөөлсөн байв. ДШБҮ-г тооцоход ашигласан үзүүлэлт болох төсвийн хөрөнгийн зарцуулалтыг зарим тохиолдолд яагаад зориулалтын бусаар ашигладаг болохыг тодруулахад удирдлагын шийдвэрээр гэж хариулсан албан хаагчдын хувь 2022 онтой харьцуулахад 5.5 оноогоор буурсан боловч төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай байдаг нь хэвээр

хадгалагдсаар л байна. Мөн 2022 онтой харьцуулахад хяналт сул байдгаас шалтгаалан төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон гэж хариулсан хариултын хувь 3.0 хувиар багассан нь холбогдох хууль, хяналтын байгууллагын төлөөллүүд энэ асуудалд анхаарал хандуулж ажилласан болохыг илэрхийлж байна. Харин уламжлал болсон учраас гэж хариулсан хариултын хувь 7.5 оноогоор өссөн нь энэхүү хэвшмэл болсон сэтгэлгээ цаашид ч мөн адил үргэлжлэх хандлагатай байна. Дүүргүүдийн ДШБҮ-ний дундаж 84.2 байгаа нь ерөнхий дундажтай харьцуулахад 0.8 оноогоор илүү үр дүн юм. Дүүргүүдээс Баянгол дүүргийн ЗДТГ хамгийн өндөр үнэлгээг авсан бол Хан-Уул болон Багахангай дүүргийн ЗДТГ-ууд хамгийн бага үнэлгээг авчээ.

БОҮ-ний 2023 оны дүн 73.7 болж 2022 онтой харьцуулахад 4.7 оноогоор нэмэгдсэн нь шударга байдлын үнэлгээ хийгдэж эхэлсэн 2015 оноос хойших хамгийн өндөр өсөлт байлаа. БОҮ-ний судалгаанд оролцогчдын авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 76.4 болж 2022 онтой харьцуулахад 2.7 оноогоор нэмэгджээ. Энэхүү үзүүлэлт 2016 оноос хойш тасралтгүй өсөж байгаа төдийгүй БОҮ-ний дунджаас 2.7 оноогоор илүү байна. Авлигыг хянах механизмын үнэлгээ 56.5 байгаа нь 2022 оны үнэлгээнээс 8.5 оноогоор нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд 2019 оноос хойш тасралтгүй буурч байсан нь энэ онд сайжирчээ. Авлигыг хянах механизмын үнэлгээ бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн бага үнэлгээтэй хэдий ч 2022 оны үнэлгээтэй харьцуулахад хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байна. Авлигыг хянах механизмыг илэрхийлэх үзүүлэлтүүдээс “Байгууллага дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог” гэсэн үзүүлэлт хамгийн олон оноогоор нэмэгджээ. Энэхүү дэд үзүүлэлтийн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн байгууллагууд нь “Стандарт, хэмжил зүйн газар” (40.2 оноогоор өссөн), “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” (37.4 оноогоор өссөн), “Онцгой байдлын ерөнхий газар” (32.5 оноогоор өссөн) юм.

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, шатгаан

Судалгаанд хамрагдсан нийт иргэд, төрийн албан хаагч, бодлогод оролцогчдийн 74.2 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл буюу ихээхэн түгээмэл байна гэж үзжээ. Энэхүү үзүүлэлт 2021 оноос хойш тасралтгүй нэмэгдэж байна. 2023 онд Монгол Улсад авлига хамгийн их тархсан институтийг “Шүүх” тэргүүлсэн байна. Үүний дараа Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага, Гаалийн байгууллага, Улс төрийн нам эрэмбэлэгдсэн байна. Энэхүү үр дүнг 2022 онтой харьцуулахад Эрүүл мэндийн байгууллагын үнэлгээ 2.4 хувиар буурсан ба Шүүх байгууллагын үнэлгээ 8.5 хувиар өсжээ. Мөн судалгааны үр дүнг дүгнэн үзэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд эдгээр байгууллагууд хоорондын байр л солигдсон болохоос авлигыг бууруулах чиглэлд ахиц гарсан ажил төдийлөн хийгдээгүй гэж үзэхээр байна.

